

**ЯПОН УЛСААС МОНГОЛ
УЛСАД ҮЗҮҮЛЭХ
ТУСЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР**

2004 оны 11 сар

МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР

Гарчиг

1. Монголын Хөгжлийн Өнөөгийн Байдал	(2-14)
(1) Хөгжлийн онцлог	(2-3)
(а) Газар зүйн онцлог	2
(б) Хүн амын онцлог	3
(в) Байгалийн нөхцөл байдлын онцлог	3
(2) Улс төрийн байдал	(3-4)
(3) Эдийн Засгийн Байдал	(4-11)
(а) Эдийн засгийн бодлого болон эдийн засгийн өсөлтийн хандлага	4
(б) Хувьчлал	6
(в) Банк, санхүүгийн салбар	6
(г) ДНБ-ны хэрэгцээний бүтэц, шийдвэрлэх асуудлууд ба ХАЁТ-ийн гүйцэтгэх үүрэг	7
(д) ДНБ-ны бүрдүүлэлтийн бүтэц, шийдвэрлэх асуудлууд ба ХАЁТ-ийн гүйцэтгэх үүрэг	8
(е) Эдийн засгийн дэд бүтцийн байдал	10
(4) Нийгмийн амьдралын байдал	(11-14)
(а) Баян ядуугийн ялгаа болон бүс нутаг хоорондын ялгааны хурцадмал байдал	11
(б) ЗЗЭЗ-ийг авч явах боловсон хүчин бэлтгэх чиглэлээр боловсролын цар хүрээг өргөтгөх шаардлага	12
(в) Эрүүл мэнд эмнэлгийн үйлчилгээг (ялангуяа хөдөө орон нутагт) сайжруулах шаардлага	12
(г) Бэлчээр талхлагдалт зэрэг байгаль орчны асуудлыг шийдвэрлэх шаардлага	13
(д) Хөдөө орон нутгийг хөгжүүлэх шаардлага	13
(е) УБ хот руу чиглэсэн хүн амын нэг туйлт төвлөрөл ба хотын хүндрэлтэй асуудлууд	14
(ё) Жендер буюу хүйсийн эрх тэгш байдлын асуудал	14
2. Монголын хөгжлийн стратеги ба Монголд үзүүлэх тусламж дэмжлэгийн хандлага	(14-21)
(1) Хөгжлийн тулгамдсан асуудлууд	(14-15)
(2) Засгийн газрын хөгжлийн хөтөлбөр	(15-18)
(а) “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”	15
(б) “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал”	17
(в) Эдийн засгийн өсөлт ба ядуурлыг бууруулах стратеги (EGPRSP)	17
(3) Өнөөг хүртлэх Япон улсаас Монголд үзүүлсэн тусламж дэмжлэг	(18-19)
(4) Бусад донорууд болон ТББ-ын Монголд үзүүлэх тусламжийн хандлага	(19-20)
(5) 10 дахь удаагийн хандивлагчдын зөвлөлгөөний өнгө төрх	(20-21)
3. Монголд үзүүлэх тусламжийн үндсэн чиглэл	(21-28)
(1) Монголд тусламж үзүүлэхийн ач холбогдол	(21-22)
(2) Монголд үзүүлэх тусламжийн чиг шугам	(22-23)
(3) Монголд үзүүлэх тусламжийн тэргүүлэх салбарууд	(23-26)
(а) ЗЗЭЗ-ийн тогтолцоог сайжруулах, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж	23
(б) Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж	24
(б)-1. Хөдөөгийн хөгжлийн бааз суурь болохуйц тодорхой загвар бүс нутагт үзүүлэх тусламж	24
(б)-2. Хөдөө аж ахуй, мал аж ахуйг сэргээхэд чиглэсэн тусламж	24
(в) Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж	25
(в)-1. Байгаль орчныг хамгаалах болон түүний баялгийг зүй зохистой ашиглах	25
(в)-2. Нийслэл УБ хот дахь байгаль орчны асуудлыг шийдвэрлэх	25
(г) Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгоход үзүүлэх тусламж	26
(4) Монголд тусламж үзүүлэхэд анхаарах зүйлүүд	(26-28)
(а) Бодлогын зөвлөлдөх уулзалт	26
(б) Бусад донорууд, Японы болон Монголын ТББ-тай уялдаа, холбоотой ажиллах	26
(в) Гадаад өрийн асуудал болон тусламж шингээх чадвар	27
(г) Байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөлөл	28
(д) Тусламжийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн үнэлгээ	28
Хавсралт. EGSPRS ба Япон Улсын З/Г-ийн ХАЁТ-ийн Бүдүүвч Зураг	29

Монгол улс 1990 оноос хойш ардчилал, зах зээлийн эдийн засгийн (ЗЗЭЗ) хөгжлийн замаар замнаж ирсэн бөгөөд энэ зам нь шулуун дардан байсангүй. Япон улс нь Монгол улстай найрсаг харилцаатай байдгийн хувьд бусад доноруудыг араасаа дагуулан, ЗЗЭЗ-т шилжих анхны жилүүдэд үүсч бий болсон нөхцөл байдалтай уялдуулж нэн яаралтай хэрэгцээ шаардлагыг хангах чиглэлээр, харин сүүлийн жилүүдэд урт хугацааны хөгжлийн зорилтуудыг хангахад чиглэсэн тусламжийг “Хөгжлийн Албан Ёсны Тусламж” (ХАЁТ)-ийн хүрээнд Монгол улсад үзүүлсээр ирсэн. Энэхүү хүч чармайлтын үрээр саяхнаас Монгол улсын эдийн засгийн түвшин ардчилалаас өмнөх үеийнхээ түвшинд эргэн хүрч чадлаа. Улмаар Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах гэсэн зорилгод хүрэхийн тулд шийдвэрлэвэл зохих олон чухал асуудал байгаа бөгөөд цаашид ч нилээд өргөн хүрээнд тусламж дэмжлэг үзүүлэх шаардлага хэвээр байсаар байна. Ойрын 5-н жилд баримтлах “Монгол улсад үзүүлэх тусламжийн хөтөлбөр”¹-ийг боловсруулж байгаатай холбогдуулж Монголын улс төр, эдийн засаг болон нийгмийн байдлын талаар иж бүрэн дүн шинжилгээ хийх нь ихээхэн чухал юм. Энэ үүднээс Монголын өнөөгийн байдлын дүн шинжилгээг 1-р бүлэгт, хөгжлийн стратеги болон бусад доноруудын тусламжийн хандлагыг 2-р бүлэгт тус тус дэлгэрэнгүй өгүүллээ.

Япон улсын ХАЁТ-ийн хэмжээ буурах хандлагатай байгаа энэ нөхцөлд Монгол улсад шаардлагатай байгаа олон төрлийн тусламж, дэмжлэгийг зөвхөн Япон улс хэрэгжүүлэх нь угаас боломжгүй зүйл юм. Япон улсын тусламжийн чиг шугамын тухай 3-р бүлэгт өгүүлсэн бөгөөд үүнд нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудлууд дотроос ойрын 5-н жилд шийдвэрлэх шаардлагатай гол асуудлууд болон үүнтэй уялдсан тусламжийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж гаргахыг зорьсон юм. Монгол улсад өргөн хүрээний тусламж дэмжлэг шаардлагатай хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд тусламжийн тодорхой чиглэлийг сонгоход хүндрэлтэй байсан хэдий ч Япон улс энэхүү хөтөлбөрийн дагуу ХАЁТ-ийн хязгаарлагдмал хөрөнгийг үр ашигтай, үр өгөөжтэй ашиглах болно.

1. Монголын Хөгжлийн Өнөөгийн Байдал

Монгол улс 1990 онд социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжин орж, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх шилжилтийн үеийг туулж ирлээ. Япон улс Монгол улсад тусалж түүнийг тогтвортой хөгжихөд нь хувь нэмрээ оруулахын тулд доорхи нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлага байна.

(1) Хөгжлийн онцлог

(а) Газар зүйн онцлог

Монгол улс 1 сая 560 мянган километр хавтгай дөрвөлжин газар нутагтай (Японоос 4 дахин том), их хэмжээний байгалийн баялаг болоод мал сүрэгтэй хэдий ч далайд гарцгүйн улмаас зөвхөн хөрш орон Орос, Хятадын гадаад далайд гарахад ашиглаж болохуйц боомтуудаар хязгаарлагддаг байна. Гэвч эдгээр боомтууд нь маш хол зайд оршдог учир бараа бүтээгдэхүүний тогтвортой тээвэрлэлт, тээврийн зардал зэрэг тал дээр Монгол улс бусад далайд шууд гарцтай орнуудтай харьцуулахад

¹ Энэхүү “Монгол Улсад Үзүүлэх Тусламжийн Хөтөлбөр”-ийг 2003 оны 3-р сард Токио дахь ажлын хэсэг, Монгол дахь ажлын хэсгийг тус тус байгуулж, Монголын засгийн газар, ТББ, эрдэмтэн мэргэдийн санаа бодлыг тусган, Монголд очиж ард түмнийх нь бодол санааг сайтар сонсон, мөн Японы ТББ-ын санаа бодлыг харгалзан зөвшилцөлд хүрсний үндсэн дээр боловсруулсан болно. Ийм өргөн хүрээнд олон талын хүмүүс оролцон Монголд үзүүлэх тусламжийн бодлогын асуудлаар нухацтай ярьж хэлэлцэн баримт бичигт боловсруулан нь анхны тохиолдол болж байна.

ашигтай бус нөхцөлд байдаг.

Гэсэн хэдий ч зүүн хойт Ази хэмээх бүс нутгийн хувьд авч үзвэл Монгол улстай хиллэх Хятадын зүүн хойт, Оросын алс дорнодын хэсэг (130 сая хүн ам), зүүн өмнөд хэсэгт байрлах Япон, Солонгосын хойгийн арлууд (197 сая хүн ам), тэдгээртэй ойр орших улс гүрнүүдийн зах зээлд гарах нөхцлийг сайтар бүрэлдүүлж чадвал Монгол улсын эдийн засаг тогтвортой өсөх боломж өндөр байна.

(б) Хүн амын онцлог

Монгол улсын хүн амын тоо хэт бага, 2003 онд дөнгөж 2 сая 504 мянгад байсан ба тэдгээрийн 40 хувь нь өргөн уудам нутагт тархай бутархай амьдардаг бөгөөд энэ нь хөдөө орон нутгийн хөгжилд илт хүндрэл учруулдаг байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын хүн амын жилийн дундаж өсөлт социализмийн үеийнхээс буурсан гэх боловч 1.2 хувь орчим буюу өндөр түвшинд хэвээр байгаа бөгөөд нийт хүн амын 72 хувийг 35 хүртлэх насны хүүхэд залуучууд эзэлж байна. Тэрчлэн хүн амын 99 хувь нь бичиг үсэг тайлагдсан нь Азийн хөгжиж буй орнуудын дотор хамгийн өндөр үзүүлэлт юм.² Өөрөөр хэлбэл Монгол улс боловсон хүчний нөөцийн хувьд өндөр чадавхитай орон юм.

(в) Байгаль орчны нөхцөл байдлын онцлог

Монгол улс хойт өргөргийн 41 хэмээс 52 хэмд орших хүйтэн бүс нутагт байрладаг бөгөөд жилийн дундаж температур ойролцоогоор 0 хэм байдаг байна. Ийм хатуу ширүүн байгаль орчин нь хөдөө аж ахуй, барилга зэрэг аж үйлдвэрлэлийн хөгжилд болон нийгмийн амьдралд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Гэсэн хэдий ч олон улсын хэмжээнд үнэлэгдэх үзэсгэлэнт байгаль нь аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай боломжийг агуулж байна. Мөн алт, зэс, молибден, газрын тос зэрэг байгалийн баялаг арвинтай бөгөөд уул уурхайн салбар далайцтай хөгжих томоохон потенциал бий.

(2) Улс төрийн байдал

Монгол улс 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш өнөөг хүртлэх бараг 15 жилийн хугацаанд төр засаг олон дахин солигдсон ч аль ч засгийн үед ардчилал зах зээлийн чиг шугамаа тууштай баримталж ирсэн ба цэрэг зэвсэгийн хүчээр улс төрийн ноёрхол тогтоож байгаагүй зэрэг утгаараа улс төрийн байдал тогтвортой байна гэж хэлж болно.

1990 оны 3-р сард социализмын улс төрийн нам болох Монгол Ардын Хувьсгалт Нам ардчилсан хөдөлгөөний өрнөлөөс үүдэн нэг намын дарангуйллын тогтолцоог өөрсдөө халж түүхэн эргэлт хийсэн. Улмаар тухайн оны 5-р сард олон намын тогтолцоог албан ёсоор хуульчилж тайван замаар ардчилал тогтоох анхны алхмаа хийсэн билээ. 1990 оны 7-р сард олон намын тогтолцооны хүрээнд УИХ-ын анхны сонгууль болсон бөгөөд парламентийн суудлын дийлэнхийг авсан МАХН дан ганц өөрсдийн намын засгийн газар байгуулалгүй, харин ардчилсан хөдөлгөөнийг дэмжигч нам болох Монголын Үндэсний Дэвшилийн Намтай эвсэж МАХН-ын дарга Бямбасүрэн тэргүүтэй эвслийн засгийн газрыг байгуулсан.³

Түүний дараа шилжилтийн эмх замбараагүй үе болох 1991 онд Монгол улсын эдийн засгийн жилийн дундаж өсөлт яалт ч үгүй 9.3 хувь орчим буурсан бөгөөд энэхүү эдийн засгийн уналтын нөлөөгөөр ардчилсан шинэ үндсэн хуулиа баталсаны (1992 оны 1 сар) дараахи 1992 оны 6-р сард

² Жишээ нь Азийн орнуудын насанд хүрсэн (эрэгтэй/эмэгтэй:%) хүмүүсийн бичиг үсэг тайлагдсан байдал: Монгол улс 99.1/98.8, Хятад улс 91.7/76.3, Вьетнам 95.5/91.4, Шри Ланк улс 94.4/89.0, 2000 оны ЮНЕСКО Азийн Соёлын Төвийн материал.

³ Ерөнхийлөгч МАХН-аас бус сөрөг хүчнээс нэр дэвшсэн П. Очирбат байв. 1990 оны 5-р сард олон намын тогтолцоо хуульчлагдсан болно.

болсон УИХ-ын сонгуулиар ард түмний шүүмжлэл тухайн үеийн эдийн засгийн бодлогыг хариуцан зах зээлийн огцом өөрчлөлтүүдийг хийсэн Үндэсний Дэвшлийн Нам руу чиглэж байснаас МАХН илт давуутайгаар олонхи болж П. Жасрай ерөнхий сайд тэргүүтэй нэг намын засгийн газар байгуулагдсан.

Гэсэн хэдий ч, 1993 онд Шинэ үндсэн хуулийн хүрээнд болсон Ерөнхийлөгчийн анхны сонгуулиар ард түмний сонголтонд өөрчлөлт гарч УИХ дахь МАХН-ын хэт давамгайллыг тэнцвэржүүлэх үүднээс цөөнхийн хүчнээс нэр дэвшсэн П. Очирбат сонгогдсон. Түүний дараа 1996 оны 6-р сард болсон УИХ-ын хоёр дахь удаагийн ээлжит сонгуулиар сөрөг хүчин байсан Үндэсний Ардчилсан Нам, Социал Демократ Намын “Ардчилсан Холбоо” Эвсэл хүч давамгайлан ялж М. Энхсайхан ерөнхий сайд бүхий эвслийн засгийн газар байгуулагдсан.

Гэвч 1997 оны 5-р сард болсон Ерөнхийлөгчийн хоёр дахь удаагийн сонгуулиар “Ардчилсан Холбоо” Эвслээс явуулсан өөрчлөлт шинэчлэлийн эрч хүчтэй бодлогоос болж тэднээс хөндийрсөн ард түмэн МАХН-аас нэр дэвшсэн Н. Багабандийг шинэ Ерөнхийлөгчөөр сонгосон.

Үүний дараахан “Ардчилсан Холбоо” Эвслийн доторхи тэргүүлэх эрх мэдлийн төлөөхи өрсөлдөөнөөс болж 1998 оны 4-р сард М. Энхсайхны засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроход хүрч засгийн газарт их хурлыг тараах эрх шинэ үндсэн хуулиар олгогдоогүй тул Үндэсний Ардчилсан Намын тэргүүн Ц. Элбэгдорж Ерөнхий Сайдын үүрэгт ажлыг хүлээн авч шинэ эвслийн засгийн газар байгуулагдсан хэдий ч төрийн өмчийн банкны хувьчлалыг тойрсон асуудлаар УИХ дээр үүссэн хүнд нөхцөл байдлаас үүдэн эвсэлийн дотор хагарал гарснаар уг засгийн газар байгуулагдсанаасаа хойш гуравхан сарын дараа буюу тэр жилийнхээ 7-р сард бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон.

Дараагийн Ерөнхий Сайдыг сонгох асуудлаар Ерөнхийлөгч Н. Багабанди болон эвслийн бүлгийн хооронд зөвшилцөлд хүрч чадахгүй нилээд хүндрэл гарсны эцэст 1998 оны 12-р сард Үндэсний Ардчилсан Намын тэргүүн Ж. Наранцацралтын тэргүүлсэн засгийн газар байгуулагдсан.⁴ Гэсэн ч Монголд нилээд чухалд тооцогдох Орос Монголын хамтарсан үйлдвэр болох Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн оросын талын эзэмшлийн хувьцааг худалдсан асуудлыг тойрон УИХ дээр дахин хүндрэлтэй байдал үүссэнээс 1999 оны 7-р сард энэ засгийн газар мөн л бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч шинэ Ерөнхий Сайдаар өмнө нь Гадаад Хэргийн Сайдын албыг хашиж байсан Үндэсний Ардчилсан Намын Р. Амаржаргал сонгогдсон.

“Ардчилсан Холбоо” эвслийн засгийн газрын улс төрийн тогтворгүй байдалд дургүйцсэн сонгогчид 2000 оны 7-р сард болсон УИХ-ын сонгуулиар дахин МАХН-ыг сонгосон (нийт 76 суудлын 72-г МАХН авсан). Энэхүү сонгуулийн дүнд Н. Энхбаярын (МАХН-ын дарга) засгийн газар (нэг намын засгийн газар) бий болсон юм. Н. Энхбаярын засгийн газар нь ардчилсан нийгэм төлөвшүүлэх, зах зээлийн эдийн засагт шилжих гэсэн өмнөх засгийн газруудын барьж ирсэн үндсэн бодлогыг үргэлжлүүлэн идэвхитэй хэрэгжүүлж ирсэн хэдий ч, 2004 оны 6-р сард болсон УИХ-ын сонгуулиар эрх баригч МАХН нам урьдын амжилтаасаа ихээхэн ухарч тал суудлаа алдсан. Сөрөг хүчний Эх орон ардчилал эвсэл ч мөн олонхи болж чадаагүй тул эцэст нь МАХН, Эх орон ардчилал эвсэл хоёр эвсэж хамтран ажиллахаар болсноор УИХ-ын даргад МАХН-аас Ерөнхий Сайд байсан Н. Энхбаяр, Ерөнхий Сайдад Эх орон ардчилал эвслээс Ц. Элбэгдорж (ардчилсан намын харьяа) нарыг тус тус сонгосон.

Нэгтгэн дүгнэхэд Монгол улсад хэд хэдэн удаа засгийн эрх ээлжлэн солигдох замаар ардчилсан нийгмийн тогтолцооны үндэс суурь тавигдсаар байна гэж хэлж болно.

(3) Эдийн Засгийн Байдал

⁴ Шинэ үндсэн хуулиар олонхи болсон нам эвслээс Ерөнхий Сайдад нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч тав хоногийн дотор УИХ-д оруулах эсвэл татгалзах эрхтэй бөгөөд харин засгийн газар нь УИХ-г тараах эрхгүй болно.

(а) Эдийн засгийн бодлого ба эдийн засгийн өсөлтийн хандлага

Монгол улс 1990 оноос хойш зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх бодлогыг, макро эдийн засгийн тогтворжилтын хамт идэвхитэй хэрэгжүүлж ирсэн. 1990 оны 7-р сараас 10-р сарын хооронд бүх ард түмэндээ хувьчлалын тасалбар тарааж улсын өмчийн хувьчлал эхэлсэн. Улмаар 1991 оны 1-р сард үнэ, үйлдвэрлэл, экспорт импорттой холбогдох бүх төрлийн дүрэм журмыг хүчингүй болгож мөн оны 5-р сараас банкны шинэ хууль хүчин төгөлдөр болсноор Монгол банк төв банк болон бие дааж, арилжааны банкнууд үүсэх зэрэг мөнгө санхүүгийн шинэ тогтолцоо бүрдэж эхэлсэн. Мөн Монгол улс 1991 оны 2-р сард Олон Улсын Валютин Сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага, улмаар 2000 оны 10-р сард Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-нд тус тус гишүүнээр элсэн орсон. (Тусламж олгох улсынхаа тоонд Монголыг багтаахын тулд ЕСБХБ 2004 оны 1-р сард болсон хурлаараа гэрээндээ өөрчлөлт оруулан баталж түүнийг нь Япон улс мөн оны 6-р сард хүлээн зөвшөөрсөн.)

Гэвч хуучин ЗХУ-ын задралыг даган социализмын тогтолцоо үгүй болсноор Монгол улс өмнө нь харилцаж ирсэн худалдааны зах зээлээ алдаж, түүнийг орлох шинэ зах зээлийг нээхэд хүндрэлтэй байсны улмаас 1990-ээс 1993 онуудад эдийн засгийн өсөлт буурахаас аргагүйд хүрсэн. Үүний улмаас 1993 оны ДНБ-ны бодит хэмжээ 1990 оны мөн үеийн түвшний 80 орчим хувьд хүртэл буурсан. Ялангуяа 1992 онд, зах зээлийн эдийн засгийн шилжилтийг дагасан эмх замбараагүй байдал, ханшны хөвөгч тогтолцооны шилжилтийг дагасан импортын барааны үнийн өсөлт, төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэсэн зэрэг үндсэн шалтгаануудаас болж, 300 хувийг давсан гүнзгий инфляц үүссэн. Ийм нөхцөл байдалд Монгол улс 1992 оны 5-р сараас ОУВС-гын бүтцийн өөрчлөлтийг сайжруулах зээлийг авч, цомхон бүтэцтэй засгийн газар бий болгох чиглэлээр удирдлагын шинэчлэлт хийх, санхүүгийн зардлыг ихээхэн бууруулах, мөнгө санхүүгийн хатуу бодлого зэрэг арга хэмжээнүүдийг авч эхэлснээс хойш Монголын эдийн засаг бага багаар сэргэх хандлагатай болсон. 2002 оны ДНБ-ний үнийн индекс өмнөх жилийнхтэй нь харьцуулахад 9.2 хувиар өсч гурван оронтой тоонд хүрч байсан 1990-ээд оны эхэн үеийг бодвол тогтворжоод байна. Сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээ 1995 оноос 2002 оны хооронд жилд дунджаар 2.7 хувь, жил тус бүрээр авч үзвэл зудтай байсан 2000, 2001 онд тус бүр 1.1 хувь, 2002 онд 4.0 хувь гэх мэтчилэн жилийн өсөлт 1-ээс 4 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол 2003 оны хувьд зуд мэтийн байгалийн гамшиг бага байсан зэргээс ДНБ-ний бодит өсөлт 5.5 хувь хүрч өссөн.

Тэрчлэн төгрөгийн доллартай харьцах ханш 1990 оны эцсээр 1 доллар 14 төгрөгтэй тэнцэж байсан бол 2003 онд 1 доллар 1168 төгрөг болж огцом унасан хэдий ч Монгол улс хүнд бэрх инфляцтай уялдуулан зохих ёсоор ханшны зохицуулалт хийж ирсэн нь үнэлүүштэй зүйл мөн. Зохих ёсоор ханшны зохицуулалт хийж ирсэний ачаар 2002 онд ДНБ-ны хэмжээ 1 тэрбум 90 сая долларт хүрч, 1 хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 442 доллар, 2003 онд ДНБ-ны хэмжээ 1 тэрбум 170 сая доллар, 1 хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 466 долларын түвшинд байна.⁵ Мөн 2003 оны хэрэглээний үнийн индекс өмнөх онтой нь харьцуулахад 4.7 хувь, ДНБ-ний үнийн индекс өмнө дурьдсаны дагуу 4.0 хувь тус тус өсч харьцангуй тогтворжиж байна.

2003 оны үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад үр тариа 31.1%, улаан буудай 30.0%, төмс 51.6 %, хүнсний ногоо 50.1%, мөн оны 10-р сарын байдлаар бөөний болон жижиглэнгийн худалдааны нэрлэсэн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.7%-аар тус тус

⁵ Дэлхийн банк Монгол улсын 2000 оны 1 хүнд оногдох орлогыг төгрөгийн доллартай харьцах бодит ханшаар тооцоолоход 390 доллар, худалдан авах чадварын дундаж (ppp) -аар тооцоолоход 1750 доллар байна гэж гаргажээ. World Bank, World Development Indicators 2002-оос үзэж болно.

өссөн байна. Тэрчлэн мөн оны 12-р сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрлэл 6.7% өсч, уул уурхайн үйлдвэрлэл 1.0% буурч, цахилгаан, дулаан, усан хангамж 1.0% өссөн байна. Цаашилбал экспортын хэмжээ 2003 оны долларт шилжүүлснээр 17.5%, импорт 16.0%, санхүүгийн орлого 12.3%, санхүүгийн зарлага 12.4% тус тус өсчээ. Дээр дурдсанчлан зуд зэрэг байгалийн гамшиг бага байснаар хөдөө аж ахуй, мал аж ахуй сэргэсэн явдал, нэхмэл сүлжмэлийн холбогдох үйлдвэрлэлийн оруулсан хувь нэмэр, худалдаа бизнесийн бусад салбарын сэргэлт зэрэг нь ДНБ 5.5 хувьтай гарахад эерэгээр нөлөөлсөн гэж бодож байна.

(б) Хувьчлал

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд хувьчлалыг идэвхитэй явуулж ирсэнээр 2002 онд ДНБ-ны 75 хувийг хувийн салбар эзлэх түвшинд хүрсэн.

Төрийн өмчийн хувьчлал 1990 оноос эхэлсэн бөгөөд мөн оны 7-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд нийт иргэдэд 10 мянган төгрөгтэй тэнцэх үнэ бүхий хувьчлалын тасалбар тараасан (нийт дүн нь тухайн үеийн төрийн өмчийн 44 хувьтай дүйцсэн гэсэн тооцоо бий). 1994 оны 3-р сард эдгээр тасалбаруудын ихэнхи нь хувьцаа болж хувирсан. Мөн онд үнэт цаасны тухай хууль гарч мөн Үнэт Цаасны Хороо байгуулагдсан. 1995 оны 8-р сард үнэт цаасны анхдагч зах зээл бий болсноор хувьчлалын эхний шат дууслаа гэж засгийн газраас зарлан тунхагласан.

Гэвч хувьчлалыг хэт яаран түргэн явуулсны уршгаар нэг компанид хэдэн мянгаас хэдэн арван мянган хувьцаа эзэмшигчдыг төрүүлсэн боловч, тэр нь зөвхөн өмчлөгчдийн нэрийг өөрчилсөн болохоос биш удирдлага, техник технологи, хөрөнгө мөнгөний тал дээр хүсч хүлээж байсан нааштай эерэг нөлөө үзүүлсэн зүйл бараг харагдаагүй юм. Мөн хувьчлалын өмнөх компаний өр хувьчлалын дараа ч тэр хэвээрээ өвлөгдөн үлдсэн. Тэрчлэн төрийн өмчийн үйлдвэрүүдийн ихэнх болох ЭЗХТЗ-ийн хөдөлмөрийн хуваарьт хамрагдан хуучин ЗХУ болон зүүн европын орнуудад голчлон бараа бүтээгдэхүүн экспортлох зорилгоор баригдсан том оврын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд нь илүүдэл хүнд дарамт болж ирсэн.

(в) Банк, санхүүгийн салбар

Монгол улс дахь зах зээлийн эдийн засгийн шилжилтийг даган банк санхүүгийн салбар либералчлагдсанаар 1996 онд 14 арилжааны банк үүсч бий болсон хэдий ч тэдгээрийн ихэнхи нь банкыг зөв удирдан авч явах арга туршлага үгүй байлаа. Мөн засгийн газрын мөнгөний өндөр хүүгийн бодлого нь хувьчлагдсан олон тооны аж ахуйн нэгжүүдийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлсний улмаас арилжааны банкнуудын зээлийн үлдэгдлийн нилээд хэсэг нь чанаргүй зээл болж хувирсан. Түүний дараа Дэлхийн Банкны удирдлага доор мөнгө, санхүүгийн өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлсний үр дүнд зээлийн баланс сайжрах хандлагатай болж банк санхүүгийн салбар шинэчлэгдэж байгаа ч банкнуудын хүлээгдэж байгаа өрийн үлдэгдлийн жилийн дундаж хүү 35 хувь орчим гэсэн өндөр үзүүлэлттэй байна. 1990 онд ДНБ-нд эзлэх мөнгөний нийлүүлэлтийн (M2) хувь 53.8 байсан бол 1995 онд энэ үзүүлэлт 18.5 хувь болж буурснаа 2002 онд 37.9 хувь болон дахин сэргэсэн ба 2003 онд 51.6 болж дахин өссөн. Гэсэн ч шууд бус банк санхүүгийн салбарт банк бус санхүүгийн байгууллагууд зах зээлийн багтаамжаас хэт олноор үүссэн байна. Үүнээс үзвэл бодит үйлдвэрлэлийн эдийн засгийн салбартай харьцуулахад мөнгө санхүүгийн салбарын хөгжил урьдын адил хоцорч явна гэж хэлж болно.

Мөн 2002 онд үнэт цаасны зах зээл дээрхи нийт мөнгөний дүнгийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ дөнгөж

2.9 хувь байсан бөгөөд 2003 онд 3.6 хувь болж арай өссөн хэдий ч мөнгөний шууд оролцоо үндсэндээ байсангүй. Үүнд 1995 онд хувьчлагдсан компаниудын дотор 470 орчим аж ахуйн нэгж тодорхой бус шалгуураар сонгогдож үнэт цаасны биржид бүртгүүлсэн нь нөлөөлсөн. 2003 оны эцсийн байдлаар үнэт цаасны биржид бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдийн тоо 402-т (бүрэн хувьчлагдсан компани 80 хувь, тал нь хувьчлагдсан компани 20 хувь) хүрээд байсан ба тэдгээрийн ихэнхийнх нь бизнес үйл ажиллагаа тааруу, биржид бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдээс дөнгөж 15 орчим нь ноогдол ашиг хуваарилж байгаа бөгөөд хэмжээн ч мөн өчүүхэн бага байгаа юм. Тэрчлэн, нийт ард түмэнд олгосон хувьчлалын тасалбар эцсийн бүлэгт 1500 орчим хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрсөн явдал нь хувьцаат компаниудын хувьцаа сайн арилжигдахгүй байгаагын гол шалтгаан болсон.

2002 онд Хөрөнгийн бирж дэх арилжааны ихэнх нь өрийн бичгийн (засгийн газрын бонд, компанийн бонд) арилжаа байсан ба энэ нь нийт арилжааны бараг 97 хувийг эзэлж байсан бөгөөд хувьцааны арилжаа 3 орчим хувиас хэтрэхгүй байлаа. Дашрамд дурьдахад, богино хугацаатай засгийн газрын бондны хүү сард 0.5-0.7 хувь, урт хугацаатай (3-н сараас дээш) засгийн газрын бондны хүү сард 1.2-1.76 хувь, компанийн бондны сард 1.6-1.65 хувь гэсэн хэмжээтэй байв. Эдгээрийг жилийн хүүд шилжүүлбэл 9-22 хувь орчим болж байгаа ба хадгаламжийн хүү болох 6-10 хувьтай харьцуулахад хөрөнгө оруулагчдын сонирхолыг татаж байгаа боловч ашиг муутай компануудын хувьд тийм өндөр хүү төлж явах нь бараг боломжгүй зүйл гэж хэлж болно.

Дээр өгүүлсэнчлэн банкны салбарт өөрчлөлт шинэчлэл ид явагдаж байгаа хэдий ч, 2000-2003 оны банкны зээлийн хүү 30-40 орчим хувийн өндөр үзүүлэлттэй хэвээрээ байгаагаас гадна хөрөнгийн бирж ч мөн хараахан хөгжиж амжаагүйн улмаас банк санхүүгийн салбар хувийн секторыг хөгжүүлэх түвшинд хүрээгүй байна.

(г) ДНБ-ний хэрэгцээний бүтэц, шийдвэрлэх асуудлууд ба ХАЁТ-ийн гүйцэтгэх үүрэг

Социализмын тогтолцоо нуран унсанаар Монгол улсын хуучны худалдааны зах зээл үгүй болж түүний оронд шинэ зах зээл олоход хүндрэлтэй байснаас 1990-ээс 1993 оны хооронд ДНБ-ний өсөлт хасах үзүүлэлттэй явж ирсэн бөгөөд 1993 оны ДНБ-ний бодит хэмжээ 1990 оны 80 орчим хувийн түвшин хүртэл унаад байсан билээ. Түүний дараа нааштай өөрчлөгдөж сүүлийн жилүүдийн өсөлт 1995 оноос 2002 он хүртэл жилд дунджаар 2.7 хувь, жил бүрээр гаргавал 2000 онд 1.1 хувь, 2001 онд 1.0 хувь, 2002 онд 4.0 хувь болж жилийн өсөлт 1-4 хувийн хооронд байна. 2000 он ба 2001 оны өсөлтийн хувь бага байгаа нь зуд болсонтой голчлон холбон үздэг.

2003 оны ДНБ-ний өсөлт 5.5 хувьд хүрээд байгаа боловч энэ нь Монгол улсын эдийн засгийн шинэ өсөлтийг зааж байна уу, эсвэл 2003 онд санаандгүй зуд зэрэг байгалийн гамшигийн хор хохирол бага байснаас шалтгаалсан уу, одоохондоо тодорхойгүй байна.

2003 оны ДНБ-ний эрэлт хэрэгцээний бүтцийн хувьд хэрэглээний хувь хэмжээ 91.0 хувь, хөрөнгө оруулалтын хувь хэмжээ 28.9 хувийг эзэлж байгаа ч хэрэглээний өндөр хувь хэмжээ нь импорт хэт давамгайлсантай холбоотой юм. Цэвэр экспортын хувь хэмжээ –19.9 хувь (барааны экспорт 52.8 хувь, импорт 69.6 хувь) болж импортын давамгайлал үргэлжилсээр байна.⁶

Улсын санхүүгийн хувьд татвар хураалтыг сайжруулах, санхүүгийн зарлагын хяналтыг хатуу чанга болгох, дотоод гадаадын зээлийг бууруулах зэрэг санхүүгийн багц арга хэмжээнүүд авсан нь үр

⁶ 1990 онд Монгол улсын экспортын 78.3 хувийг, импортын 77.5 хувийг Орос улс эзэлж байсан бол түүнээс хойш худалдааны зах зээлийн бүтэц огцом өөрчлөгдсөн. 2003 онд экспортын 47.2 хувийг Хятад, 32.3 хувийг АНУ, 6.3 хувийг Орос улс, 4.7 хувийг БНСУ, Япон ойролцоогоор 1.2 хувийг эзэлж, импортын 34.7 хувийг Орос улс, 20.5 хувийг Хятад, 11.8 хувийг БНСУ, 4.8 хувийг Япон улс эзэлж байна. National Statistical Office of Mongolia, Mongolia Statistical Yearbook, 2000, 2001, 2002, 2003 болон Monthly Bulletin of Statistics 2003 оны 10, 11, 12-р сар, 2004 оны 1-6 сарын дугаар, ADB-Key Indicators 2004-өөс авав.

өгөөжөө өгч 1999 онд ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хувь 11.9 байсан бол 2003 онд 5.9 хувь болж буурсан. Энэ үзүүлэлт хэдийгээр ОУВС-гийн зөвлөмж болгосон төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 6.0 хувиас хэтрүүлэхгүй байлгах гэсэнтэй нийцэж байгаа ч, төсөв урьдын адил алдагдалтай хэвээр байгаа учир энэ байдлыг үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай байна.⁷

Мөн 2002 оны хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийн 66.3 хувь гадаадын тусламжаас гаралтай байсан ба энэ нь тусламжийн ачаар дөнгөж эдийн засгийн эерэг өсөлтийг хадгалж байгаа гэсэн үг. Монгол улс ДНБ-нийхээ 20 орчим хувьтай тэнцэх хэмжээний хөгжлийн албан ёсны тусламж авдаг бөгөөд гадаадын тусламжаас хамаарах хувь хэмжээ Азийн бусад орнуудтай харьцуулахад өндөр байна. Олон улсын байгууллагын шугамаар олгосон тусламжийг оролцуулан өнөөг хүртлэх бүх тусламжийн 40 гаруй хувийг, голлох донор улсуудаас хоёр талт хамтын ажиллагааны шугамаар олгосон тусламжийн 70 орчим хувийг Япон улсын ХАЁТ эзэлж байна.

Тэрчлэн албан ёсны гадаад өр ДНБ-ний 94.0 хувийг (2002 онд) эзэлж байгаа боловч өр барагдуулалтын хувь хэмжээ 6.7 хувь гэсэн харьцангуй тогтвортой түвшинд байгаа бөгөөд Монгол улсын гадаад өр нь цааш барагдуулж явж болохуйц түвшинд байна гэж олон улсын санхүүгийн байгууллагууд дүгнэж байна. Харин Япон улсын хувьд Монгол улсаас Япон улсад төлөх үндсэн болон зээлийн хүүгийн төлбөрийн хэмжээ ойрын хэдэн жилийн дотор оргилдоо хүрэх учир, өдгөө бид Монгол улсын өрийн удирдлага хяналтын байдлыг анхааралтай нягтлан харж байна.

Нөгөө талаар дээрхи өрөөс тусдаа тооцогддог удаан хугацаанд санаа зовоож байсан ОХУ-д төлөх өрийн хувьд хуучин Зөвлөлт Холбоот Улсын үеийн өрийн 97.8 хувийг чөлөөлөх тухай ОХУ-тай тохиролцоонд хүрч 2003 оны 12-р сарын 26-нд үлдэгдэл болох 250 сая ам. долларыг төлж дуусгасан тухай 2003 оны 12-р сарын 31-нд зарлагдсан. ОХУ-д төлөх өрийн асуудлыг нааштайгаар шийдвэрлэсэн нь Монгол улсын өр төлөх чадварын хувьд олон улсын тавцан дахь итгэлийг дээшлүүлсэн ач холбогдолтой хэдий ч, 250 сая ам. долларын нилээд нь дотоодын өр болж хувирснаас цаашдын санхүүгийн удирдлага болон гадаад зээлийг хүлээж авах чадварт сөрөг нөлөө үзүүлэх зэрэг асуудлуудыг сайтар нягтлан үзэх шаардлагатай байна.

Тэрчлэн Япон зэрэг донор орнуудын тусламжаар нүүрс олборлолт, эрчим хүч, холбоо, төмөр зам зэрэг материаллаг дэд бүтэц, гадаадын хөрөнгө оруулалтын хууль зэрэг биет бус дэд бүтцүүд бий болсны ачаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бага багаар нэмэгдэж 2002 онд хийгдсэн гэрээ хэлэлцээрийн нийт дүн ДНБ-ний 7 хувийн хэмжээнд хүрээд байна. 1990-ээс 2000 оны хоорондох гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт дүнгийн 23.5 хувь нь уул уурхайн салбарт, 19.4 хувь нь хөнгөн үйлдвэрийн салбарт ноогдож байна. Мөн 2001 онд хийгдсэн гэрээ хэлэлцээрийн дүнг улс бүрээр ялгавал БНХАУ 36.0 хувь, БНСУ 16.5 хувь, Япон улс 1.1 хувь болж байна.

Ингээд Монгол улсын макро эдийн засаг нь сүүлийн жилүүдэд тогтворжиж эхэлсэн гэж хэлж болох боловч, өсөлтийн чадвар сул дорой хэвээр, гадаад худалдааны болон санхүүгийн алдагдал үргэлжилсээр байгаа бөгөөд тэдгээрийн шалтгаан болох хувийн сектор хараахан бэхжиж амжаагүй, татвар хураах тогтолцоог сайжруулснаар татварын орлого нэмэгдэх байдал харагдаж байгаа ч татварын орлого дутагдах гэх мэт хүндрэлүүд хэвээр байгаа зэргээс үзэхэд макро эдийн засгийн тогтворжилтыг найдвартай хангахад олон шийдэгдэж амжаагүй асуудлууд байсаар байна.

(д) ДНБ-ны бүрдүүлэлтийн бүтэц, шийдвэрлэх асуудлууд ба ХАЁТ-ийн гүйцэтгэх үүрэг

⁷ Засгийн газар цаашдын санхүүгийн шинэчлэлийн хүрээнд төсвийн бүрдүүлэлт, хэрэгжилт, түүнд тавих хяналт шалгалтыг улам хүчтэй болгох, дунд хугацааны төсвийн хүрээ бий болгох, төсвийг тэргүүлэх чиглэлийн бодлоготой уялдуулах, төсвийг бүхэлд нь сайжруулах, санхүүгийн нэгдсэн дансны систем, тайлан мэдээллийн тогтолцоог сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус бий болгож байна.

• Аж үйлдвэрлэлийн бүтэц

Уул уурхай аж үйлдвэрлэлийн салбарын хөгжил сул дорой байснаас шалтгаалан Монгол улсын гол салбар болох хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин 1990 онд 15.2 хувь байснаа 1995 онд 38.0 хувь болж өссөн. Гэвч энэ салбарын 2002 оны хувийн жин өмнөх 2 жилийн ган зудын нөлөөгөөр 20.7 хувь болж огцом буурсан ба 2003 онд 20 хувьтай байна.⁸ Мөн 2000 оноос хойш шүлхий зэрэг малын өвчин гарах нь ихсэж шинээр бэрхшээл үүсгэж байна.

Уул уурхай аж үйлдвэрийн салбар нь Монгол улсын эдийн засгийн үндэс суурийг бүрдүүлэгч хэвээр байгаа бөгөөд түүний ДНБ-нд эзлэх хувь хэмжээ 2003 онд 19.1 хувь байсны дотор, уул уурхайн салбар 9.5 хувь, үйлдвэрлэл 6.0 хувийг эзэлж байлаа. Экспортод эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээ 34.8 хувь, ноос ноолууран бүтээгдэхүүний хувь хэмжээ 26.8 хувь байж Монгол улсын экспорт зэс, молибден гэсэн эрдэс баялаг, ноос ноолууран бүтээгдэхүүн дээр тогтсон хэвээр байна.⁹

Сүүлийн жилүүдэд эрдэс баялгийн экспорт нэмэгдэж байгаа нь Монголын эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлж байна. Жишээ нь БНХАУ-д экспортлох зэсийн баяжмалын хэмжээ огцом нэмэгдсээр байна. Гэвч Монгол улсын экспорт бүтцийн хувьд нэмүү өртөгийн бүтээмж багатай эрдэс баялагаас хамааралтай байгаа нь үр өгөөж муутай юм. Мөн зэс, алт зэргийн олон улсын зах зээлийн үнэ 1995 оноос хойш буурах хандлагатай байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд өсч эхэлж байна гэж байгаа ч ихээхэн тогтворгүй байна. Дээр нь экспортын нэг хэсгийг бүрдүүлж буй ноос ноолуурын үйлдвэрлэлд ч хүндрэлтэй асуудлууд байсаар байна. Ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэл анх Япон улсын тусламжаар бий болсон түүхтэй бөгөөд 1980-аад оны үед гадаад валют олох гол эх үүсвэр болж байсан билээ. 2003 он гэхэд экспортод томоохон хувь нэмэр оруулсан хэвээр байсан бөгөөд малчдыг бэлэн мөнгөний эх үүсвэртэй болоход ч мөн хувь нэмрээ оруулсан. Гэвч ноос ноолуурын түүхий эд Хятад руу урсан гарч дотоодын үйлдвэрүүд түүхий эдээр гачигдах, ямааны тоо толгой өссөнөөс бэлчээр талхлагдах зэрэг асуудлууд тулгарсаар байна. Монголын гадаад валют олох гол хэрэгсэл болох ноос ноолуурыг хамарсан экспортын үйлдвэрлэлийн хувьд түүхий эдээ гадагшаа алдах нь ноцтой асуудал бөгөөд цаашид түүхий эдийн экспорт, барааны импорттой холбоотой худалдааны асуудлуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ түүхий эдийн чанарыг дээшлүүлж түүн дээрээ дотооддоо нэмүү өртөг үйлдвэрлэх замаар өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн болгон экспортлох чиглэл рүү яаж авч явах вэ гэсэн үйлдвэрлэлийн асуудлуудыг ч мөн шийдвэрлэх нь Монгол улсад тулгараад байгаа чухал зорилтын нэг мөн.

2003 онд үйлчилгээний салбарын ДНБ-нд эзлэх жин 58.5 хувь байна.¹⁰ Энэ хувь хэмжээг худалдаа наймаа хөгжиж зах зээлд олон тооны бараа үзэгдэх болсонтой холбон үзэхээсээ илүү харин ч уул уурхай, хөдөө аж ахуй мал аж ахуй болон үйлдвэрлэлийн салбарын сул хөгжил үүнд ихээхэн нөлөөлсөн бөгөөд хөгжлийг даган гарч буй зүй ёсны ахиц хэмээн үзэх аргагүй. Монгол улсын өргөн уудам зүйл бүрийн байгалийн үзэсгэлт газарт тулгуурласан аялал жуулчлал нь гадаад валют олох ихээхэн боломжтой салбар хэдий ч ДНБ-ийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж чадахгүй байгаа бөгөөд гадаадын жуулчны тоо жилд дөнгөж 50 мянган хүн гэсэн бага түвшинтэй байна.

⁸ Таван хошуу малын тоо толгой 1990 онд 25 сая 860 мянга байснаас 1999 онд 33 сая 570 мянгад хүрч өссөн хэдий ч зудаас болж 2002 онд 23 сая 900 мянга, 2003 онд 25 сая 428 мянга болсон. Задаргаа хийвэл 1) адуу (1 сая 968 мянга 900), 2) үхэр (2 сая 567 мянга), 3) хонь (10 сая 756 мянга 400), 4) ямаа (10 сая 652 мянга 900), 5) тэмээ (256 мянга 700). Мөн улаан буудайн үйлдвэрлэл 1990 онд 596 мянган тонн байсан бол 2003 онд 160 мянга 400 тонн болсон. Тухайн оны газрын үр өгөөжийн хэмжээ 1 гектарт ойролцоогоор 0.8 тонн гэсэн маш бага түвшинтэй байна.

⁹ 2003 онд үйлдвэрлэсэн зэсийн баяжмал 372 мянган тонн, алт 11.1 тонн байв. Зэсийн баяжмал дахь зэсийн агуулга 32 хувь орчим байснаа сүүлийн жилүүдэд 25 орчим хувь болж буурчээ.

¹⁰ Дотор нь задалбал худалдаа 28.8 хувь, зочид буудал нийтийн хоол 1.2 хувь, харилцаа холбоо 15.1 хувийг тус тус эзэлж байна.

- **Ажил эрхлэлтийн бүтэц**

Монгол улсад нийт ажил эрхлэж буй 927 мянган хүн амын (2003 онд) 42 орчим хувьтай тэнцэх 390 мянган хүн хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт харьяалагддаг бөгөөд энэ утгаар нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарыг суурь салбар гэж хэлж болох юм. Анх зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнөхөн (1989 онд) хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт ажиллагсдын тоо 32.0 хувь буюу 244 мянга байснаа шилжилтын дараа буюу 1999 онд 45 хувь болж өссөний цаад учир нь шилжилтын хүнд бэрх үеийн үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны уналтаас болж ажилгүй болсон хүмүүс (146 мянган хүн) аргагүйн эрхэнд мал аж ахуйн салбар руу шилжсэн явдал болно.

Нэг талаас 2003 онд уул уурхай аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын хувь хэмжээ 11.7 хувь, мөн уул уурхайн салбарт ажиллагсдын тоо 3.4 хувиас хэтрэхгүй байгаа бөгөөд үйлдвэрлэлийн салбарынх 5.9 хувь байна. Иймээс уул уурхайн салбарыг хөгжүүлэх нь чухал боловч их хэмжээний ажлын хүч шингээх боломж муутай юм. Үйлчилгээний салбарт ажиллагсдын хувь 42.6 байгаа хэдий ч тэдгээрийн дотор тогтмол ажилгүй хувийн наймаачид зэрэг хүмүүс их байна.¹¹

Өнөөдөр Монгол улсын хөдөө аж ахуй, мал аж ахуй болон үйлчилгээний салбарт ажиллах хүчний илүүдэл үүсч албан бус секторыг үүсгэж байна. Энэ асуудлыг шийдэхгүй бол ядуурлын үндсэн асуудал шийдвэрлэгдэхгүй. Өөрөөр хэлбэл Монголын эдийн засгийн ирээдүйн хувьд мал аж ахуйн салбар дахь илүүдэл ажлын хүчийг шинээр ажлын байр бий болгох замаар хэрхэн шингээх вэ гэдэг нь хамгийн чухал асуудал болоод байна.

Бэлчээрийн даац хэтрэх асуудлын тухайд малчдын тоо огцом өссөнөөр эрс нэмэгдсэн малын тоо толгой (тэмээ, морь, үхэр, хонь, ямаа) нь бэлчээр талхлагдалт, малын халдварт өвчин болон зуд зэргээс шалтгаалан богино хугацаанд огцом буурч 2002 онд 23 сая 898 мянга болж хамгийн олон толгой малтай байсан 1999 онтой харьцуулахад ойролцоогоор 9 сая 760 мянгаар тоо толгой нь буурснаас бэлчээрийн даац хэтрэх асуудал нэг хэсэгтээ намжиж байна¹².

(е) Эдийн засгийн дэд бүтцийн байдал

Монгол улс өргөн уудам нутагтай, хүн ам хэт цөөн бөгөөд тархай бутархай байрладаг гэсэн онцлогтойгоос гадна хүн амын нилээд хэсэг нь суурин бус нүүдэллэн явдаг онцлогтой аж ахуй эрхэлдэг. Энэ нь хөдөө орон нутагт тусламж дэмжлэг үзүүлэхэд гол хүндрэл болдог бөгөөд эдийн засгийн дэд бүтцийг авч үзэх тохиолдолд энэ онцлогоос урган гарах хязгаарлалтуудыг тооцож үзэхгүй бол болохгүй. Цаашилбал, Монгол улсын бүх хил нь газраар байдаг учир тэр бүх хязгаар нутгуудад тархан суусан малчдад нийгмийн үйлчилгээг хүргэх замаар нийт нутаг орноо хамгаалах, аюулгүй байдлаа баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.

Иймээс Монгол улсыг далайд гарцгүй хязгаарлагдмал байдлаас гарахад нь туслах шаардлагатай бөгөөд Япон улс төмөр замыг засч сайжруулах замаар аюулгүй найдвартай тээвэрлэлтийг баталгаажуулах, БНХАУ-тай хиллэдэг Замын Үүдэд ачаа шилжүүлэн ачих байгууламжийг барьж, ачааны вагон худалдаж авах, төмөр замын тээврийн хүчин чадлыг сайжруулах зэрэгт тусалцаа үзүүлж ирлээ.¹³ Мөн Азийн хөгжлийн Банк, Япон улс болон бусад холбогдох улсын тусламжаар Улаанбаатар хотын доторхи болон түүний ойр хавь, нийслэлээс хойш Оросын хил хүртэл, цаашилбал Дархан Эрдэнэтийн хооронд гэх зэрэг газруудад зам засах, барих ажлууд хийгдэж ирлээ. Мөн хэтдээ

¹¹ 2002 онд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 30,877 буюу ажилгүйдлийн хувь 3.4 болж өмнөх оны 4.6 хувьтай харьцуулахад бага зэрэг сайжирсан боловч 2003 онд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 33,335 болж ажилгүйдэл 8.0 хувь болж өссөн.

¹² Гэвч өмнө өгүүлсэнчлэн 2003 оны малын тоо бага зэрэг сэргэж 25 сая 428 мянга болсон.

¹³ Монгол улс ОХУ-аас олон тооны ачааны вагон түрээслэн ашиглаж байсан бөгөөд Япон улс ачааны вагон худалдан авахад тусалснаар зардлыг бууруулж гадаад валют хэмнэх болсноор ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Зүүн хойт ази, евро азиар нэвтрэх зам гарцын хүрээнд өрнө дорнын чиглэлийн гол зам барих асуудал яригдаж байгаа бөгөөд түүний нэг хэсгийг Монголын засгийн газраас “Мянганы Зам” хэмээн нэрлэн хэсэг хэсгээр сайжруулах, барих ажил эхлээд байна.

Цахилгаан эрчим хүчний хангамжийн хувьд, 1990 онд үйлдвэрлэж байсан 3 тэрбум 576 сая квт/цаг гэсэн хэмжээнд хүрээгүй ч Япон улсын тусламжаар 1995 онд 3 тэрбум 10 сая квт/цаг, 2003 онд 3 тэрбум 310 сая квт/цагийн түвшинд барьж ирлээ. Цахилгаан болон дулааны эрчим хүчээр найдвартай хангах болсноор жирийн ард иргэд урьдийнхаасаа илүүтэйгээр эрүүл мэнд, харилцаа холбоо зэрэг нийгмийн үйлчилгээг хүртэх боломжтой болсноос гадна дотоод болон гадаадын хөрөнгө оруулалтаар үйлдвэр аж ахуйн газрууд сэргэн босож шинээр үүсч бий болох боломж бүрдсэнийг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм. Гэсэн хэдий ч ирээдүйн эдийн засгийн хөгжлийн үүднээс авч үзвэл цахилгаан эрчим хүчний хангамж дутагдалтай болох төлөвтэй бөгөөд ихээхэн хуучирч ноцтой байдалтай болсон нийслэл хот дахь гол цахилгаан станцуудыг засварлахын оронд эртхэн шинэ станц барих шаардлага тулгараад байна. Тэрчлэн цахилгааны төлбөр барагдуулалтын асуудал зэргийг нэг мөр шийдвэрлэж, цахилгаан станцуудын удирдлагын үр ашгийг улам дээшлүүлэх шаардлагатай байна. Хөдөө орон нутгийн цахилгааны хангамжийн хувьд Япон улсын тусламжаар нарны эрчим хүчээр ажиллах цахилгаан үүсгүүрүүд нэлээд нэвтэрч, төвийн эрчим хүчний системтэй холбогдоогүй сумдад дизель станцууд суурилуулж дууссан хэдий ч дизелийн түлшээр найдвартай хангах, засвар үйлчилгээний зардал төлбөрийн тогтолцоог яаж шийдэх тухай асуудал, мөн цахилгааны хангамж сайтай болон засвар үйлчилгээ нь хүндрэлтэй байгаа газруудын хоорондын ялгааны асуудал ч мөн гарч байна.

Цаг агаар гэнэт муудах, түргэн тусламж дуудах зэрэг гамшигийн үед яаралтай арга хэмжээ авахад зориулж Япон улсаас нийлүүлсэн богино долгионы холбоо нийт улсын 340 сум, 1671 багийг хамарч байгаа бөгөөд Монголын талаас маш өндөр үнэлгээ авч байгаа. Япон улсын йений зээлээр (Төмөр замын тээврийн хүчин чадлыг сайжруулах төсөл 2) нийлүүлсэн шилэн кабель 1 сая шугамын багтаамжтай бөгөөд өнөөдөр урдаас хойт чиглэлд дэлхий нийттэй холбох ажил хийгдэж байна. Мөн БНСУ-ын тусламжаар Улаанбаатараас зүүн чиглэлд зүүн хойт Азитай холбогдох шугам тавигдсан. Цаашилбал, нийслэл болон аймгийн төвүүдэд интернет ашиглах явдал нэвтэрч байна. 1990 оны үед улс хоорондын яриа ч холбогдохгүй их далайн дунд дахь тусгаарлагдсан арал мэт хүнд нөхцөлд байсан холбооны салбар Япон улсын тусламж дэмжлэгтэйгээр сүүлийн жилүүдэд огцом хурдтай хөгжиж байна.

Өнгөрсөн 15 жилд дэд бүтцийн бүтээн байгуулалтанд тодорхой ахиц дэвшил гарсан нь үнэн. Гэвч нийт дэд бүтцийн хувьд тэдгээрийн засвар үйлчилгээ, арчилгаа тордолгоог зохих ёсоор явуулах бүтэц тогтолцоог хэрхэн сайжруулах, дэд бүтцийн эдийн засгийн үр ашгийг хэрхэн дээшлүүлэх зэрэг шийдвэрлэх ёстой асуудлууд байсаар байна.

(4) Нийгмийн амьдралын байдал

(а) Баян ядуугийн ялгаа болон бүс нутаг хоорондын ялгааны хурцадмал байдал

Монгол улсад сүүлийн жилүүдэд баян хоосны ялгаа огцом нэмэгдэж ядуурал ноцтой асуудал болоод байна. Энэ бүхний учир шалгаан нь өмнө өгүүлсэнчлэн социалист тогтолцоо нуран унснаар Монголын экспортын зах зээл үгүй болсон явдал, төрийн өмчийн үйлдвэрүүдийг хэт яаран хувьчилснаар үйлдвэрлэлийн салбар уналтанд орж тэндээс үүссэн ажилгүйчүүд мал аж ахуйд шилжсэн боловч туршлага дутмаг байснаас, мөн хатуу ширүүн байгалийн нөхцөлөөс мал аж ахуй эрхлэх орчин муудсан зэрэг болно.

Нийслэл болон хөдөө орон нутгийн хоорондын бүс нутгийн ялгаа ч мөн ил тод болж байна. 2001 онд

1 хүнд ноогдох ДНБ-ийг аймаг бүрээр гаргахад Өвөрхангай хамгийн бага 182 доллар, 8-н аймагт 200-299 доллар, 10 аймагт 300-399 доллар, харин Говь-сүмбэр аймагт улсын дундаж түвшин болох 442 доллар (2002 он)-оос арай бага буюу 437 доллар байна. Дундаж түвшинийг давж гарсан нь Орхон аймаг 551 доллар, хамгийн өндөр үзүүлэлт Улаанбаатар хотод 709 доллар байна. Бүс нутгийн ялгаа нь зөвхөн эдийн засгийн түвшинд бус нийгмийн түвшинд хүрч хөдөө орон нутгийн нийгмийн амьдралын үндэс суурь нурж эхэлж байна. Мөн 2003 оноос газар хувьчлал эхэлсэн бөгөөд түүний нийгэм эдийн засгийн үр нөлөөг анхааралтай ажиглах хэрэгтэй болж байна.

Цаашилбал хот суурин газар дахь ядуурал ч мөн өссөөр байна. Анх зах зээлийн эдийн засагт шилжих эхэн үед илүүдэл ажлын хүч хотоос хөдөөд шилжсэн боловч сүүлийн жилүүдэд хөдөөд амьдрах боломжгүй болсон ядуучуудын давхарга Улаанбаатар зэрэг хот суурин газар руу нүүж ирж, тэнд нь ч мөн ажил олох боломж муу тул ядуучуудын хорооллыг үүсгэж тэр нь жил ирэх тутам өсөн нэмэгдсээр байна.

Монгол дахь энэхүү ядуурлын гол шалтгаан нь аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын уналттай холбоотой нь ойлгомжтой. Эдийн засгийн уналтаас үүдэлтэй ажилгүйдэл, мал хувьчлалын дараа зуд зэрэг байгалийн гамшигийн уршгаар малаа алдсанаас үүдсэн ядуурал зэрэг нь ноцтой асуудал болоод байна. Гэр бүл салалт, олон хүүхэд төрүүлэх зэргээс шалтгаалж хот суурин газарт өрх толгойлсон эхчүүдийн тоо өсөх хандлагатай байгаа¹⁴ болон архи согтууруулах ундаанаас болж гэр бүл сарних зэрэг нь ч мөн ядуурлын гол шалтгаан болж байна. Улсын хэмжээнд 4, 712 өнчин хүүхэд, 43, 569 хагас өнчин хүүхэд, 4-өөс дээш хүүхэдтэй өрхийн тоо 57, 556 буюу нийт 568, 625 гэр бүлийн 10 орчим хувь болж байна¹⁵ (2002 он).

Монголын засгийн газраас ядууд тооцогдох хүмүүсийг амьдралын доод түвшинөөр тодорхойлсон бөгөөд энэ нь бүс нутаг бүрт их бага хэмжээгээр ялгаатай ч сард 19, 500 төгрөгөөс (ойролцоогоор 2,000 йен) 25, 300 төгрөг (ойролцоогоор 2, 600 йен) хүртлэхээс бага орлоготой хүмүүсийг ядууд тооцож байна. Нийт улсын хэмжээнд хүн амын 35.6 хувь нь ядууд тооцогдож байгаа бөгөөд хот суурин газрын хүн амын 39.4 хувь нь ядуу бүлэгт хамаарч байна (1998 он).

(6) 33ЭЗ-ийг авч явах боловсон хүчин бэлтгэх чиглэлээр боловсролын цар хүрээг өргөтгөх шаардлага

Монгол улсын хүн амын 99 хувь нь бичиг үсэгт тайлагдсан гэсэн өндөр үзүүлэлттэй бөгөөд энэ нь социалист тогтолцооны үеийн төр засгийн бүтээсэн амжилт гавьяа юм. Гэвч өдгөө 33ЭЗ-ийг авч явах боловсон хүчин ноцтойгоор дутагдаж байна. Бага дунд боловсролын хувьд сургуулийн байр хүрэлцээгүйгээс сурагчид өглөө, өдөр, орой гэсэн 3-н ээлжээр хичээллэхэд хүрч буй асуудал, сургууль завсардалтын асуудал, хот хөдөөгийн боловсролын түвшиний ялгаа, олон улсын стандартаас ялгаатай боловсролын тогтолцоо (одоо 10-н жил суралцаж төгсөөд их дээд сургуульд орж байгаа), багшлах боловсон хүчин бэлтгэх, сургалтыг материалаар хангах зэрэг шийдвэрлэх ёстой олон асуудлууд байна.

Тэрчлэн сүүлийн жилүүдэд их дээд сургуулийн тоо огцом нэмэгдэж байгаа хэдий ч, хичээлийн агуулга хүсч буй түвшинд хүрээгүй, мэргэжлийн өндөр мэдлэг, технологийг олж авах боловсролын байгууллага тун ховор байгаа тул гадаадад дээд боловсрол эзэмших хүсэлтэй хүмүүс олон байна. Иймээс 33ЭЗ-ийг авч явах боловсон хүчин бэлтгэхэд бага, дунд, дээд болон нарийн мэргэжил

¹⁴ Эмэгтэй хүнээр өрх толгойлуулсан гэр бүлийн нийгэмд эзлэх байр суурь эрэгтэй хүн толгойлсон гэр бүлтэй харьцуулахад доогуур бөгөөд ядууралд автахдаа хялбар байдаг.

¹⁵ 2002 онд хотын айл өрхийн тоо 311, 965, хөдөө тосгоны айл өрхийн тоо 256, 660 байсан.

эзэмшүүлэх бүх түвшингийн боловсролын чанар агуулгыг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага байна.

(в) Эрүүл мэнд эмнэлгийн үйлчилгээг (ялангуяа хөдөө орон нутагт) сайжруулах шаардлага

Монгол хүний дундаж наслалт эрэгтэй хүн 64, эмэгтэй хүн 67 байдаг. Монголын эрүүл мэнд эмнэлгийн салбарт шийдвэрлэх ёстой асуудал бол жирэмсэн эхчүүдийн нас баралтын өндөр хувь¹⁶ ба хөдөө орон нутагт эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээний түвшин доогуур байгаа асуудал юм.

Сүүлийн жилүүдэд нярай хүүхдийн эндэгдэл болон жирэмсэн эхчүүдийн нас баралт буурах хандлагатай байгаа ч аль аль нь өндөр түвшинд хэвээр байна. Бараг бүх төрөлт нарийн мэргэжлийн эмч, эх баригчийн хяналтанд явагдаж байгаа боловч, нас баралт өндөр байгаа явдал нь нас баралтын шалтгаанд дүн шинжилгээ хийж, шалтгааныг арилгахад чиглэсэн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах шаардлага урган гарч байна¹⁷. Үүнтэй зэрэгцэн сүрьеэ, вируст гепатит, бруцеллөз¹⁸, бэлгийн замын халдварт өвчин зэрэг халдварт өвчнүүдтэй тэмцэх шаардлага ч мөн байна.

Хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээний хувьд засгийн газраас хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг үр өгөөжтэй болгох, үйлчилгээнийх нь чанарыг дээшлүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах замаар ядуу болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн зардлыг хөнгөлөх зэрэг бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ч санхүү, боловсон хүчний дутагдал, эмч нар мэргэжлээрээ ажиллахгүй байгаа зэрэг асуудлууд байгаа бөгөөд 33ЭЗ дахь эрүүл мэндийн тогтолцоог бий болгохын тулд цаашид хийх зүйл их байна¹⁹.

Эдгээр нөхцөл байдлыг сайжруулахын тулд одоо эрүүл мэндийн яам голлох үүрэгтэйгээр эрүүл мэндийн салбарын хөгжлийн стратегийг боловсруулж байна.

(г) Бэлчээр талхлагдалт зэрэг байгаль орчны асуудлыг шийдвэрлэх шаардлага

Унаган байгалийн бэлчээр дээр тулгуурладаг мал аж ахуй нь бэлчээрийн гарц, монголын экологийн тогтолцоог хадгалж хамгаалахтай салшгүй холбоотой юм. Гэвч сүүлийн жилүүдэд Монголд социализмийн үед байгуулсан худгуудыг арчилж хадгалж чадаагүйгээс үлдсэн цөөн тооны мал усалгааны газар мал сүрэг бөөнөөрөө цугларах болсноос тэр хавийн бэлчээр талхлагдах үзэгдэл ихээхэн гарах боллоо. Мөн малын гаралтай түүхий эдийн худалдааны тогтолцоо сайн хөгжөөгүйгээс түүхий эдээ борлуулах зах зээлд ойр байх үүднээс хот суурин газрын ойролцоо малчид төвлөрөх болсноор бэлчээр талхлагдах явдал гарч байна. Цаашилбал бэлчээрийн даац хэтэрснээс бэлчээр талхлагдах, цөлжилт явагдахын зэрэгцээ хадлан тэжээл дутагдсанаас болж ган зуд болох бүрийд

¹⁶ 1985-1990 оны хооронд хүүхэд төрүүлсэн 100 мянган эх тутамд 120-175 эх нас барж байсан бол энэ үзүүлэлт 1993 онд 240 болж өссөн. Сүүлийн жилүүдэд энэ тоо буурч ойролцоогоор 160 орчим болсон ч бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад өндөр түвшинд хэвээр байна.

¹⁷ 2002 онд төрөлтийн хувь 1.91, нас баралтын хувь 0.64, нярайн эндэгдэл 1000 хүн тутамд 29.6 хүн байна. Нэг жилд 46, 922 хүн шинээр мэндэлж, 15, 857 хүн нас барж, цэвэр өсөлт 31, 065 хүн байна. Жирэмсэн эхчүүдийн нас баралтын тоо (бодит тоо) 2001 онд 82 хүн, 2002 онд 57 хүн байлаа.

¹⁸ Бруцеллөз өвчин нь дэлхийн өнцөг бүрт тархаад байгаа хүн амьтанд адилхан халдварладаг өвчний нэг бөгөөд малаас болон боловсруулаагүй сүүн бүтээгдэхүүн хэрэглэснээс халдварладаг. Өвчний шинж тэмдэг нь халуурах, ядарч туйлдах, сэтгэл санаагаар унах зэрэг ерөнхий шинж тэмдэгүүд илэрдэг ба бүх төрлийн дотоод эрхтэнд халдварладаг.

¹⁹ 2002 онд эмнэлгийн орны нийт тоо 18, 616, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын тоо 33, 273 хүн (27, 384 нь эмэгтэй), эмч 6, 823 (5, 296 нь эмэгтэй), мөн нийслэлийн эмч нарын тоо 3, 971, эм зүйч 587 хүн байна. Нийт улсын дунджаар 360 хүн тутамд 1 эмч ноогдож байна. Гэхдээ хөдөө орон нутагт эмч эмнэлгийн мэргэжлийн хүн дутагдалтай байгаагийн нэг учир шалтгаан нь эмчийн мэргэжилтэй мөртлөө мэргэжлээрээ ажиллахгүй хүн олон байгаа байдалд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Монголын эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хувьд 1990 онд 70.3 хувь нь улсын төсвөөс, 29.7 хувь нь эрүүл мэндийн даатгалаас санхүүжигдэж байсан бол 2002 онд 53.9 хувь улсын төсөв, 41.8 хувь эрүүл мэндийн даатгал, 4.3 хувь нь төлбөрт үйлчилгээ болоод байна.

олон тооны малаа алдах байдал ч хурц асуудлын нэг болж байна.

(д) Хөдөө орон нутгийг хөгжүүлэх шаардлага

Өмнө өгүүлсэнчлэн 1990 оноос хойш төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газрыг яаран хувьчилсан болон социализмын үед малын гаралтай бүтээгдэхүүнүүдийг экспортлодог байсан хуучин ЗХУ болон зүүн европын зах зээл үгүй болсноос хотын төдийгүй хөдөө орон нутгийн үйлдвэрлэл уналтанд орж тэр үед баригдаж байсан олон тооны барилга байгууламжууд тухайн аж ахуйн нэгж дамбуурснаас дутуу чигээрээ орхигдсон. Дээр нь хөдөө нутагт бэлчээр талхлагдаж, цөлжилт явагдан ган зудын нөлөөгөөр мал аж ахуй, газар тариалан уналтанд орж улмаар шилжилтийн үеийн эмх замбараагүй байдлын нөлөөгөөр цахилгаан дулаан, цэвэр бохир усны хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг салбарууд ч социализмын үеийн түвшингөөсөө доройтох зэргээр нийгмийн амьдралын үндэс суурь илт муудан хөдөө орон нутгаас хүмүүс олноороо хот суурин газар руу шилжин ирэх болж үүнийг зохицуулах боломжгүй байдалд ороод байна. Иймээс ч Монголын засгийн газар хөдөө орон нутгийг хөгжүүлэх асуудалд ихээхэн ач холбогдол өгч хөгжлийн голлох тулгуур төвүүдийг байгуулах бодлого боловсруулж байна.

(е) УБ хот руу чиглэсэн хүн амын нэг туйлт төвлөрөл ба хотын хүндрэлтэй асуудлууд

Өмнө өгүүлсэнчлэн хөдөө орон нутгаас хүмүүс хот руу ялангуяа УБ хот руу олноороо шилжин ирэх болсноос 1992 онд УБ хотод 580 мянга хүн амьдарч байсан бол одоо Монголын нийт хүн амын болох 2 сая 504 мянган хүний 1 сая 100 мянга орчим нь УБ хотод амьдарч байна гэж яригдах боллоо²⁰. Угаасаа дэд бүтэц нь хуучирч муудсан УБ хотын хүн ам ихээр өссөнөөс хог хаягдлын асуудал, цэвэр бохир усны асуудал, гэр хорооллын айлуудын нүүрс түлэлтээс үүдэлтэй агаарын бохирдолтын асуудал, дулаан хангамжийн дутагдал зэрэг асуудлууд улам хурцадмал болоод байна.

(ё) Жендер буюу хүйсийн эрх тэгш байдлын асуудал

Социализмийн үед эрэгтэй эмэгтэйчүүд хамтдаа эдийн засаг нийгмийн үйл ажиллагаанд оролцох зарчимтай байсан бөгөөд ардчилал зах зээлд шилжсэнээс хойш ч энэ зарчим үндсэндээ хадгалагдаж үлдсэн. Ажил эрхлэж буй 25-аас 50 хүртлэх насны хүмүүсийн хүйсний ялгааг авч үзвэл бараг ижил түвшинд байна. Монгол улсад их дээд сургуульд суралцагч эмэгтэйчүүд, ТББ, хувийн хэвшил, төрийн байгууллагуудад ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувь хэмжээ Японоос ч өндөр түвшинд байдаг.

Гэвч ардчилал өрнөснөөс хойш өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өсөхийн зэрэгцээ ясли цэцэрлэг төлбөртэй болох зэргээр эмэгтэйчүүдийн үүрэх ачаалал нэмэгдсээр байна²¹. Цаашилбал төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газрын хувьчлал, үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын үр шимийг голчлон эрэгтэйчүүд хүртэж эмэгтэйчүүд хуучны уламжлалын дагуу өв хөрөнгө эзэмших эрх нь хязгаарлагдмал бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд ч мөн албан бус сектороор хязгаарлагдаж байна.

2. Монголын хөгжлийн стратеги ба Монголд үзүүлэх тусламж дэмжлэгийн хандлага

(1) Хөгжлийн тулгамдсан асуудлууд

²⁰ 2003 онд нийслэлийн албан ёсны хүн ам 893 мянга, 2002 онд нийт нутгийн дунджаар 1 ам дөрвөлжин талбайд 1.58 хүн, харин нийслэлд энэ үзүүлэлт 180 хүн болсон байна. 2003 онд хүн амын 35.7 хувь, ДНБ-ний 57.8 хувь нь нийслэлд төвлөрч байна.

²¹ 2002 онд өрх толгойлсон эхчүүд бүхий гэр бүлийн тоо 61,765 буюу нийт өрх айлын 11 хувийг эзэлж байна. Мөн 16 хүртлэх насны хүүхэдтэй ганц бие эмэгтэйчүүдийн тоо 46,298 байна. Мөн тухайн жилд нийт 13,514 хос шинээр гэр бүл болж, 688 хос гэрлэлтээ цуцлуулжээ.

Монгол улс 33ЭЗ-т шилжсэний дараа тун удалгүй 1990-ээд оны эхний хагас гэхэд эдийн засгийн уналтаас гарч чадан сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт нэмэх үзүүлэлттэй явж байна²². Энэхүү амжилт нь бараг ижил нөхцөл байдалтай төв азийн бусад улс орнуудтай харьцуулахад ерөнхийдөө амжилттай явж байна гэж хэлж болох болов уу.

Гэсэн ч эцсийн бүлэгт 2003 оны эдийн засгийн түвшин 1990 оны түвшингөөс ялимгүй давснаас хэтрэхгүй байна. Тэрчлэн энэ хугацаанд эдийн засаг болон ажлын байрны бүтцэд хоёуланд нь томоохон өөрчлөлт орж энэ нь баян ядуугийн ялгаа болон бүс нутгийн ялгааг улам нэмэгдүүлсэн.

Ялангуяа, хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын уналт нь шийдвэрлэх ёстой чухал асуудал болоод байна. Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг сэргээхэд эдгээр салбарын үр өгөөжийг дээшлүүлэх нь чухал бөгөөд тодруулж хэлбэл энэ салбарт байгаа илүүдэл ажлын хүчийг өөр салбарт шилжүүлэх нь чухал байна. Энэ үүднээс авч үзвэл ирээдүйд нэмэгдэх ажиллах хүч болон өнөөг хүртэл хөгжлөөс хоцорч үлдсэн ядуучуудын давхаргыг ч давхар тооцоход ойрын 10 орчим жилд 200 мянгаас 300 мянган ажлын байр шинээр бий болгох шаардлага гарч байна.

Иймээс ойрын 10-н жилийн төлөвийг авч үзвэл үнэхээр тогтвортой хөгжлийнхөө замд орж чадах уу үгүй юу гэсэн салаа замын уулзварт ирээд байна гэж хэлж болно. Энэ цаг үед Монгол улсад тулгараад байгаа шийдвэрлэх ёстой онцгой асуудлуудыг дараахи маягаар товчлон томъёолж болох юм.

- 33ЭЗ-т шилжих үйл явцыг гүнзгийрүүлэх, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл, хувийн хэвшлийг хөгжүүлэх, банк санхүүгийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, дэд бүтцийг сайжруулж ажлын байрыг шинээр бий болгох замаар ажиллах хүч илүүдэлтэй байгаа мал аж ахуйн салбараас ажиллах хүчийг шилжүүлэх зэрэг асуудлыг шийдэж чадах эсэх,
- Ядуурал, бүс нутгийн ялгаа, байгаль орчны бохирдолт зэрэг улам бүр хурцадмал болж буй нийгмийн амьдралын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх,
- 33ЭЗ-т шилжсэнээр хувийн хэвшил төрийн байгууллагуудын боловсон хүчин бэлтгэх, удирдах чадвар болон бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх чадварыг хэрхэн сайжруулах,
- Монгол улс далайд гарцгүй эх газарт байрладгаасаа болж зах зээлд гарах боломж муу байдаг бөгөөд энэ байдлыг даван туулж Зүүн Хойт Азийн зах зээлтэй холбогдох замаар эдийн засгаа хөгжүүлж чадах эсэх, зэрэг болно.

Монгол улсад үйлдвэр аж ахуйн нэгжийн хувьчлал, газар хувьчлал зэрэг эдийн засгийг либералчлах үйл явц хурдтай явагдаж байгаа бөгөөд засгийн газар ч мөн олон шинэ бодлого, хууль тогтоомжийг ар араас нь цувруулан боловсруулан гаргаж байна. Иймээс эдгээр чиг хандлагыг сайн тооцоолж харсны үндсэн дээр тусламж үзүүлэх шаардлагатай.

(2) Монгол улсын засгийн газрын хөгжлийн хөтөлбөр

Монгол улсын засгийн газар дунд хугацааны хөгжлийн гол стратеги болгож 2000-аас 2004 онд хэрэгжүүлэх “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”, “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”, мөн засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд “Эдийн засгийн өсөлт ба ядуурлыг бууруулах стратеги” буюу EGSPRS-ийг боловсруулж гаргасан²³. EGSPRS бол Монголын

²² 1990 оныг 100 хувь гэж үзвэл Монгол улсын ДНБ-ний бодит хэмжээ 2002 онд 104.7 хувь байсан бөгөөд Казахстаны энэ үзүүлэлт 77.9 хувь, Киргизых 69.8 хувь байсан. <<ADB, KEY INDICATORS OF DEVELOPING ASIAN AND PACIFIC COUNTRIES 2003>>

²³ Economic Growth Support and Poverty Reduction Strategy Paper

засгийн газрын идэвхи санаачлагаар бүх донор улс, олон улсын байгууллага, олон тооны ТТБ-уудын оролцоотойгоор боловсруулагдсан баримт бичиг бөгөөд донор улс олон улсын байгууллагууд тусламж хамтын ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ энэ баримт бичигтэй уялдуулах шаардлага гарч байна.

(а) “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”

2000 онд байгуулагдсан Н. Энхбаяр тэргүүтэй МАХН-ын засгийн газар 2000 оноос 2004 он хүртлэх “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”-ийг боловсруулсан бөгөөд энэ нь Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах гэсэн үндсэн зорилготой байсан ба доорхи үндсэн чиглэл болон салбар тус бүрийн бодлогыг тодорхойлсон.

1. Үндсэн Чиглэл

- 1-1. Эдийн засгийн эрс шинэчлэл ба экспортод чиглэсэн эдийн засгийн өсөлт
- 1-2. Боловсрол соёлыг хөгжүүлэх, хамгаалах
- 1-3. Ашиг орлогын хуваарилалтыг боловсронгуй болгох замаар ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх, үр өгөөжтэй тогтолцоог хөгжүүлснээр нийгмийн халамжийг сайжруулах
- 1-4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж хот хөдөөгийн ялгааг арилгах

2. Салбар тус бүрийн Бодлого

2-1. Нийгмийн Бодлого

Суурь боловсрол болон нарийн мэргэжил эзэмжүүлэх сургалт явуулах, эмнэлгийн чанартай үйлчилгээ ба урьдчилан сэргийлэх үйлчилгээ явуулах замаар эрүүл мэндийн байдлыг сайжруулах, дорнын соёлын онцлог болон дэлхийн түвшинтэй уялдуулан соёл, урлаг, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх, баялаг болон орлогын хуваарилалтыг сайжруулах, баян ядуугийн ялгааг арилгах.

2-2. Эдийн засгийн бодлого

Макро эдийн засгийг тогтворжуулах, санхүү банкны салбарыг эрүүлжүүлэх, хувьчлалын үйл явцыг үргэлжүүлэх болон улам өгөөжтэй болгох. Дотоодын үйлдвэрлэлийг сэргээх, экспортыг хөгжүүлэх, уул уурхайн салбарыг бэхжүүлэх, мал аж ахуйн салбарын уналтыг хяналтандаа авах, аялал жуулчлал, хөдөө орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх.

2-3. Бүс нутгийн, орон нутгийн хөгжлийн бодлого

Хөдөө орон нутгийн онцлогийг харгалзсан татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлого хэрэгжүүлэх, нийт нутгийг 5-н бүсэд хуваасан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх²⁴.

2-4. Байгаль орчны бодлого.

Байгаль орчны асуудлыг давхар тооцоолсон эдийн засгийн өсөлт, хөдөө орон нутагт байгалийн баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдсон үүрэг хариуцлагыг тодорхой болгох.

2-5. Гадаад бодлого

Хилийн бүсэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон ЗХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг хөгжүүлэх, Япон улстай иж бүрэн түншлэлийг бэхжүүлэн хөгжүүлэх, Ази номхон далайн улс орнуудтай харилцаагаа бэхжүүлэх зэрэг.

2-6. Засаглалыг бэхжүүлэх, нийгмийн дэг журмыг хангах, хууль журмыг сахиулах.

Бодлогыг үр үгөөжтэй хэрэгжүүлэх, ард түмэнд чиглэсэн үр өгөөжтэй үйлчилгээ, хууль тогтоох зэрэг

²⁴ 2003 онд УИХ-аас Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 5-н бүсэд хувааж түүний дотор нийслэлийг оролцуулахгүйгээр 4-н бүс тус бүрт 2 хот, нийтдээ 8-н тулгуур хот дээр тулгуурласан хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. Эдгээр бүс, тулгуур хотууд нь: 1) Баруун бүс (Ховд, Улиастай), 2) Хангайн Бүс (Хархорин, Эрдэнэт), 3) Төвийн бүс (Зуун мод, Дархан), 4) Зүүн Бүс (Чойбалсан, Өндөрхаан), 5) Нийслэл УБ хот бөгөөд тодорхой хөгжлийн төлөвлөгөө нь одоо боловсруулах шатандаа байна. 2004 оны УИХ-ын сонгуулын дараа эндгээр 5-н бүс нутгийг үлдээх эсэх асуудлаар зохицуулалт хийгдэж байна. 2004 оны 9-р сарын байдлаар МАХН-ын дээрхи 5-н бүс нутагтай холбогдуулж ардчилсан холбоо эвслээс нийслэлийг хамарсан төвийн бүсийг илүүтэй анхаарсан бодлогыг дэвшүүлж байгаа.

засаглалыг сайжруулах, олон нийтийн үйлчилгээний хариуцлагын тогтолцоог сайжруулах, эрх зүйн далайцтай шинэчлэл ба түүний хэрэгжилтийг сайжруулах замаар гэмт хэрэг, хээл хахууль, авилгалын үндсийг таслах.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр нь ерөнхий асуудлуудыг дурдсан байгаа бөгөөд тоон үзүүлэлтүүд дутмаг болсон хэдий ч Монголын засгийн газар эзний ёсоор идэвхи санаачлага гарган бодлогынхоо чиг шугамыг тодорхойлсныг үнэлүүштэй юм. Уг мөрийн хөтөлбөрийн нийгэм эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлүүд нь төлөвлөгдсөний дагуу хэрэгжиж чадвал сүүлийн жил болох 2004 онд эдийн засгийн өсөлт 6 хувь, ДНБ-д эзлэх санхүүгийн алдагдал 5.7 хувь, ДНБ дэхь урсгал орлого 4 хувь хүрч макро эдийн засаг тогтворжино гэж тайлбарлагдаж байна.

(б) “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал”

2001 онд засгийн газрын мөрийн хөтөлбөрийн доторхи нийгэм эдийн засгийн хөгжлийн салбарын нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой зорилтуудыг нэгтгэсэн “хүний аюулгүй байдлын төлөөх сайн засаглал” гэсэн чиглэлийг тодорхойлж дараахи 11 асуудлийг гарган тавьсан.

- (1) Макро эдийн засгийн тогтворжилт ба эдийн засгийг сэргээх үйл явцыг бэхжүүлэх
- (2) Банк санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх
- (3) Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ба сэргээх, экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах
- (4) Хөдөө орон нутгийг хөгжүүлэх ба дэд бүтцийг сайжруулах
- (5) Боловсон хүчин бэлтгэх ба нийгмийн салбарыг бэхжүүлэх
- (6) Ажилгүйдлийг бууруулах ба амьдралын түвшинг дээшлүүлэх
- (7) Байгаль орчныг хамгаалах
- (8) Газрын шинэчлэлийг урагшлуулах
- (9) Орчны бохирдолт ба хогны асуудлыг шийдвэрлэх
- (10) Хүний аюулгүй байдлыг хангах
- (11) Ардчилал хүний эрхийг хамгаалах

(в) Эдийн засгийн өсөлт ба ядуурлыг бууруулах стратеги (EGSPRS)

Монголын засгийн газар санхүү эдийн засгийн яам дээр бүх яам газруудыг хамарсан зөвлөл байгуулж дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 1999 оноос “Ядуурлыг бууруулах Стратегийн Баримт Бичиг” (PRSP)-ийг боловсруулж эхэлсэн бөгөөд “Full - PRSP”-г боловсруулах явцад нэр нь “Ядуурлыг бууруулах Стратегийн Баримт Бичиг” (PRSP)-ээс “Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих Ядуурлыг Бууруулах Стратеги” (EGSPRS) болж шинэчлэгдсэн. EGSPRS нь эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах гэсэн засгийн газрын чиглэлийг гол болгохын зэрэгцээ доорхи 5-н зүйл дээр тулгуурлан эдийн засаг, нийгмийн хөгжлөө тэнцвэртэйгээр хөгжүүлэх стратеги болсон.

- (а) Макро эдийн засгийн тогтворжилт ба төрийн байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх
- (б) ЗЗЭЗ-т шилжих шилжилт болон хувийн секторт тулгуурласан эдийн засгийн өсөлт бий болгох тогтолцоо, орчинг бүрдүүлэх
- (в) Экологийн тэнцвэрийг хадгалан бүс нутаг, орон нутгийг тогтвортой хөгжүүлэх
- (г) Тогтвортойгоор хүнийг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хангамжийн үйлчилгээг сайжруулах замаар шударга хуваарилалт хийх
- (д) Сайн засаглал ба хүйсийн эрх тэгш байдлыг хангах

EGSPRS-ийг бүхэлд нь хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж эргэн тайлагнах ерөнхий зохицуулалтыг Санхүү эдийн засгийн яамны Ядуурлыг бууруулах судалгааны хэсэг хийж гүйцэтгэхээр болоод байна. Санхүү эдийн засгийн яамны зохицуулалтын доор бүх салбарын яамд тодорхой хугацаанд тодорхой бодлогын зорилтод хүрэх зорилгоор төрөл бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Мөн холбогдох яам, газар, албан байгууллага эсвэл ТББ EGSPRS-д тусгагдсан тодорхой төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналтыг хуваан авч гүйцэтгэнэ. Ядуурлыг бууруулах судалгааны групп нь эдгээр олон төрлийн үйл ажиллагааны байдлыг нэгтгэн үнэлж засгийн газар, УИХ болон Дэлхийн Банк зэрэг холбогдох байгууллагуудад явц, ахицын тайланг гарган өгч байхаар болоод байна.

Монголын засгийн газар жил хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлдог “Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл”-ийг боловсруулахдаа засгийн газрын мөрийн хөтөлбөр, EGSPRS, Мянганы Хөгжлийн Зорилтууд (MDGs)-ийн хоорондын уялдаа холбоог хангахын зэрэгцээ, эдгээр 3-н хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг сайтар мэдсэний үндсэн дээр үндсэн чиглэлийг боловсруулах үед мониторинг хийх замаар холбогдох бодлогыг үндсэн чиглэлд тусгаж байхаар болсон. Шинэ засгийн газраас авч хэрэгжүүлэх эдийн засгийн бодлого, хөгжлийн зорилтуудын хувьд одоогоор тодорхой болоогүй байгаа ч өмнөх засгийн газрын үед боловсруулсан EGSPRS-ийн дагуу хөгжих байр суурь хэвээр байх болов уу гэж бодож байна²⁵.

(3) Өнөөг хүртлэх Япон улсаас Монголд үзүүлсэн тусламж дэмжлэг

Япон улс 1972 онд Монгол улстай дипломат харилцаа тогтоосноос хойш дипломат үйл ажиллагаагаа тууштай хөгжүүлж ирсэн бөгөөд 1990 он хүртэл нийт 6 тэрбум йенийн тусламж үзүүлсэн. Үүнд дотоодод боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан ноолуурын үйлдвэр (5 тэрбум йен) багтаж байгаа бөгөөд энэ үйлдвэр социализмын үеийн Монгол улсын хувьд гадаад валют олоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

1991 оноос өнөөг хүртэл Япон улс шилжилтийн үеийн эмх замбараагүй байдлаас үүдэн Монгол улсад яаралтай шаардагдах болсон хэрэгцээг хангахад чиглэсэн тусламжаас эхлэн улмаар эрчим хүч, холбоо, тээвэр (төмөр зам, авто зам зэрэг) гэх мэт эдийн засгийн хөгжлийн үндсийг сайжруулахад голлон чиглэсэн дунд урт хугацааны хөгжлийн шаардлага, 33ЭЗ-т амжилттай шилжихэд шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, тогтолцоог сайжруулах, хөдөө аж ахуй, мал аж ахуйг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, ус хангамж, хүнсний тусламж гэх мэт амьдралын үндсэн хэрэгцээний салбаруудад чиглэн хамгийн том хандивлагчийн хувьд Монгол улсад идэвхитэйгээр тусалж дэмжиж ирсэн. Мөн Япон улс АХБ, ДБ, ОУВС зэрэг олон улсын байгууллагуудад элсэх зэрэг Монгол улсын олон улсын нийгэмлэгт оролцох оролцоог идэвхитэй дэмжиж ирсэн. Дашрамд дурдахад 1991 оноос 2003 онуудад Япон улсаас үзүүлсэн зээл тусламж 36 тэрбум 126 сая йений зээл, 68 тэрбум 810 сая йений буцалтгүй тусламж, 23 тэрбум 342 сая йены техникийн хамтын ажиллагаа бүгд 128 тэрбум 278 сая йен болж байгаа бөгөөд энэ нь хоёр талын хамтын ажиллагааны шугамаар Монгол улсад үзүүлсэн гадаадын зээл тусламжийн 70 орчим хувийг эзэлж байна²⁶.

Япон улсаас Монгол улсад үзүүлсэн зээл тусламж нь дээр өгүүлсэнчлэн юуны өмнө хүнс, ус, эрүүл мэнд, боловсрол гэх мэт хүний амьдралд хамгийн чухал салбаруудыг дэмжиж, дараагийн дугаарт эрчим хүч, харилцаа холбоо, зам тээвэр (төмөр зам, авто зам гэх мэт), мал аж ахуйг хөгжүүлэх болон

²⁵ Дашрамд дурдахад “Эх орон ардчилал” эвсэл өмнөх засгийн газрын баримталж байсан гадаад бодлогыг үргэлжлүүлнэ гэдгээ зарлан тунхагласан.

²⁶ 2003 оны санхүүгийн жилд буцалтгүй тусламж 3 тэрбум 85 сая йен, техникийн хамтын ажиллагаа 1 тэрбум 526 сая йен нийтдээ 4 тэрбум 611 сая йен болсон.

аж үйлдвэрлэлийн үндэс суурийг дэмжихэд чиглэсэн тусламж дэмжлэгийг хамгийн том донор улс болж хэрэгжүүлж ирсэнээр Монгол улс социализмийн эдийн засгаас ЗЗЭЗ-т шилжихэд голлох үүрэг гүйцэтгэсэн гэж хэлж болно.

Энэхүү Япон улсын тусламж дэмжлэгийг “Усанд живж байсан Монголыг Япон аварч эмнэлэгт хэвтсэнийх дараа голлон эмчилсэн. Цаашид ч Япон улсыг дөнгөж эмнэлгээс гараад байгаа Монгол улсын өмөг түшиг асран хамгаалагч болохыг хүсч байна” гэх мэтээр Монгол улсын зүгээс өндөрөөр үнэлдэг.

Япон улсаас өнөөг хүртэл үзүүлж ирсэн тусламж дэмжлэгийн дотроос дараахи төслүүдийг онцгойлон үнэлдэг. Үүнд дэд бүтцийн салбарт “Холбооны Байгууламжийг Сайжруулах Төсөл”-ийн хүрээнд сансрын холбооны газрын станц суурилуулсан, “Замын Үүдэд Ачаа Шилжүүлэн Ачих Байгууламжийг Сайжруулах Төсөл”-ийн хүрээнд контейнерийн ачаа шилжүүлэн ачих байгууламж барьсан, “Асфальтан зам тавих төсөл” болон бусад төслийн хүрээнд тавьсан засмал зам, 4-р цахилгаан станцын шинэчлэлийн төсөл, “УБ хотын нийтийн тээврийн хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд нийслэлд нийлүүлсэн автобус, “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын өргөтгөл төсөл”-ийн хүрээнд барьсан сургуулийн барилгууд, “Сумдын төвийн дизель станцыг шинэчлэх төсөл”-ийн хүрээнд хөдөө орон нутагт нийлүүлсэн дизелийн цахилгаан станцууд болно. Яаралтай буцалтгүй тусламжаар “Хүнсний тусламж”, “Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тусламж”, “Яаралтай тусламж”-аар нийлүүлсэн богино долгионы радио станц, “Өвчний үндэс” буцалтгүй тусламжаар сургуулийн байрны засвар, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр, дэд бүтцийн салбар болон бусад салбарт (4-р цахилгаан станц, автобус компани, Дарханы төмөрлөгийн үйлдвэр) боловсон хүчин бэлтгэсэн зэрэг болно.

Нөгөө талаас ЗЗЭЗ-т шилжих үйл явц өндөр хурдтайгаар явагдсанаас удирдлага, менежментийн тогтолцоо нурж тусламжаар нийлүүлсэн тоног төхөөрөмж, байгууламжийг хангалттай ашиглаж чадахгүй байсан, эсвэл Монголын тал хөрөнгө санхүүгийн дутагдлаас болж засвар үйлчилгээний хөрөнгө байхгүй байх зэрэг шалтгаанаар үр өгөөжийг нь хүртэх хүртэл тодорхой хугацаа шаардсан зэрэг тохиолдлууд гарч байсан. Цаашид хэрэгжүүлэх төслийг сонгохдоо урьд өмнө хэрэгжүүлсэн төслүүдээс сургамж авч тухайн төслийг хэрэгжүүлэх шаардлага, гарах үр дүнгээр хязгаарлагдалгүй Монголын талын улс төр, эдийн засаг, нийгэм болон бусад салбар хүрээ, тэдгээрийн хөгжлийн хандлагыг урьдынхаас илүүтэйгээр сайтар харгалзан үзэх шаардлага гарч байна.

(4) Бусад донорууд болон ТББ-ын Монголд үзүүлэх тусламжийн хандлага

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Монгол улсын голлох донорууд нь Япон, АХБ, ДБ байсан. Эдгээр донорууд бүгд Монгол улсын шилжитийн үед тулгарч буй асуудлуудыг сайтар ойлгож 2004 оноос 3-аас 5-н жилийн хугацаанд хэрэгжүүлэх тус тусын дунд хугацааны тусламжийн хөтөлбөрийг боловсруулж байна.

(а) Азийн хөгжлийн банк нь Япон улсын дараа орох 2 дахь том хандивлагч бөгөөд 1991 оноос өнөөг хүртэл 54 сая долларын техникийн хамтын ажиллагаа, 570 сая долларын зээл олгоод байна. 2003 он хүртэл 6-н салбар (хөдөө аж ахуй, мөнгө санхүү, нийтийн үйлчилгээний салбарыг сэргээх, нийгмийн салбар, хот хөгжүүлэх, зам)-ийг тусламжийн тэргүүлэх салбар болгон тусламж үзүүлж ирсэн бөгөөд цаашид ч эдгээр салбарт тусламжаа үргэлжлүүлэн үзүүлэхээр төлөвлөж байна.

(б) Дэлхийн банк нь 3 дахь том хандивлагч бөгөөд 1991 оноос өнөөг хүртэл нийт 300 сая долларын тусламж үзүүлээд байна. Үүний 51 хувь нь дэд бүтэц, 23 хувь нь банк санхүү, 12 хувь нь ядуурал, тус бүр 8 хувь хувийн хэвшил болон засаглалын салбарт ноогдож байна. Тусламжийн цаашдын төлөвийн

хувьд Монголын засгийн газрын хамгийн чухал зорилт болох EGSPRS-д голлон анхаарах болов уу. Үүнд хүрэхийн тулд төрийн байгууллагуудын шинэчлэлт, хувийн хэвшлийг дэмжих, нийгмийн салбарыг дэмжихэд түлхүү ач холбогдол өгөх байх. Мөн дэд бүтэц (зам, хөдөөгийн цахилгаанжуулалт) болон хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд голлон анхаарна гэдэг нь тодорхой болоод байна.

(в) АНУ-ын тусламж өнөөг хүртэл хүнсний тусламж (буудай) болон техникийн хамтын ажиллагаа төдийхнөөр хязгаарлагдаж байсан боловч 2003 оны 9-р сард 2004-өөс 2008 онд хэрэгжүүлэх Монголд үзүүлэх тусламжийн хөтөлбөрөө нийтэд зарлаж уг хөтөлбөртөө хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар Монголын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад туслах болон засаглалыг сайжруулахад хүч чармайлт тавихаа онцлон дурдсан. Тэрчлэн АНУ “Мянганы Сорилтын Сан” буюу МСА –ийн тусламж үзүүлэх шалгуурыг давсан 63 орныг нийтэд зарласан бөгөөд эдгээрийн дотор Зүүн Хойт Азид байрладаг цорын ганц улс нь Монгол улс тул цаашдын үйл явдалын өрнөл ихээхэн анхаарал татаж байна.

(г) БНХАУ өнөөдөр голлох хандивлагч улс биш боловч худалдаа, шууд хөрөнгө оруулалтын хувьд Монгол улсын хамгийн том түнш юм. БНХАУ-аас Монголд үзүүлсэн тусламж нь барилга, уул уурхай зэрэг салбарт зээл болон буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжиж ирсэн. Өнгөрсөн 2003 оны 6-р сард БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол улсад айлчлах үеэр 300 сая долларын зээл олгохоор амласан бөгөөд мөн оны 11-р сард болсон хандивлагчдын зөвлөлгөөн дээр Монгол улс зөвхөн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл цаашид авах бодолтой байгаагаа илэрхийлсэн тул уг зээлийг хөнгөлөлттэй зээл болгох чиглэлээр яриа хэлэлцээр хийгдэж байгаа ба цаашидын хандлага нь ихээхэн анхаарал татаж байна.

(д) ОХУ ч мөн голлох хандивлагч биш боловч өнгөрсөн 2003 оны 12-р сард Монголын ОХУ-д төлөх өрийн асуудал шийдвэрлэгдсэн учир цаашид Монгол, ОХУ хоёр улсын хоорондын эдийн засаг, эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ ахиц гарах боломж бий болоод байна. Мөн Монголын тал урдаас хойт чиглэлийн төмөр замын дагуу ОХУ-ын хил дээр “Алтанбулагийн Худалдааны Чөлөөт Бүс” байгуулж байгаа бөгөөд энэ нь Оросын талтай хийх худалдааг улам хөгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд Монголын тал Сибирийн зах зээлийг ихээхэн сонирхож байгаагийн илрэл гэж ч хэлж болно.

(е) ТББ-ын үйл ажиллагаа

Ардчилалын үйл явц эхэлснээс хойш Монгол улсад олон улсын ТББ, дотоодын ТББ, Японы ТББ-ууд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлст идэвхитэй оролцож байна. Ялангуяа эрүүл мэнд боловсролын салбарт “Дэлхийн зөн”, “ADRA”, “Save the Children” зэрэг олон улсын ТББ-уудын үйл ажиллагаа илт идэвхижиж байна. Япон улсын ТББ-ууд ч хот суурин газрын хүүхдүүдэд туслах болон 1999 оноос хойш ган, зудаас шалтгаалан малгүй болсон малчидад туслах зэргээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

(5) 10 дахь удаагийн Хандивлагчдын зөвлөлгөөний өнгө төрх

2003 оны 11 дүгээр сарын 19-21-ний өдөр Дэлхийн банк болон Монгол Улсаар хамтран даргалуулсан Монголд хандивлагчдын 10-р зөвлөлгөөнийг манай улс Токио хотноо зохион байгууллаа. Хамгийн сүүлийн удаа гадаадад зохион байгуулагдсан уг зөвлөлгөөнөөр, өнгөрсөн 10 жилийн тусламжийн үйл ажиллагааг дүгнэх, Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, EGSPRS буюу эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд авч үзэх тусламжийн арга хэлбэр болон хандивлагчдын цаашид үзүүлэх зээл тусламж зэргийн талаар хэлэлцсэн юм.

Тодруулбал, урт хугацааны хөгжлийн хүрээнд олон салбарын өсөлт хөгжлийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгох шаардлагатай байгааг тодорхойлсон. Мөн, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд хувийн хэвшил давамгайлсан хөрөнгө оруулалтыг өргөжүүлэн нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох шаардлагатай ба үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын орчин болон хувийн хэвшлийн удирдлагын орчин нөхцлийг сайжруулах, хувийн хэвшил давамгайлсан хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, төрийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг цомхтгох, төсвийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж, түүнийг хамгаалан тайлагнах хариуцлагыг өндөрсгөх, засаглалыг боловсронгуй болгох зэрэг нь чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн юм. Улмаар, ядуурлыг бууруулах, Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхийн тулд хөдөөг хөгжүүлэх, үйлчилгээг сайжруулахын ач холбогдол, огцом хурдтай явагдаж буй хотжилт болон хот суурин газрын ядууралтай тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тухай хэлэлцэв.

Зөвлөлгөөний үеэр хандивлагчид нийт 335 сая ам.долларын тусламж, дэмжлэг үзүүлэх тухай мэдэгдэв. Манай улс 2003 онд 4 тэрбум 611 сая йенийн туслалцаа үзүүлэхээ илэрхийлсэн. Энэхүү зөвлөгөөний төгсгөлд Дэлхийн банкны зүгээс нийт хандивлагчдыг төлөөлөн, манай улсын өнөөг хүртэлх урт хугацаанд Монголд үзүүлсэн тусламж, гүйцэтгэж ирсэн үүрэг үлэмж их хэмээн өндрөөр үнэлсэн билээ.

3. Монголд үзүүлэх тусламжийн үндсэн чиглэл

(1) Монголд тусламж үзүүлэхийн ач холбогдол

(а) Монгол орон нь Хятад, Орос хэмээх хоёр их гүрний дунд орших далайд гарцгүй улс болохынхоо хувьд Зүүн Хойд Азийн бүс нутагт улс төрийн газар зүйн чухал байр суурийг эзэлдэг. Монгол Улс ардчилсан тогтолцоог тогтоон хөгжүүлэх нь бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад нөлөөтэй гэж үздэг. Тус бүс нутаг нь Япон улсын аюулгүй байдал, мөн эдийн засгийн хөгжил цэцэглэлттэй гүн гүнзгий уялдаа холбоотой байдаг бөгөөд Япон улсын хувьд түүний ач холбогдол нь өсөн нэмэгдсээр байна.

(б) Манай хоёр орон, дипломат харилцааны түүхийн үүднээс үзэхэд нэлээн нягт харилцаатай. Монгол орон социалист нийгмийн тогтолцоонд байсан тэр үеэс манай хоёр улс найрсаг харилцаатай явж ирсэн бөгөөд 1990 оноос хойш энэхүү харилцаа улам бүр бэхжиж, олон салбарт харилцах чиг хандлага бүрэлдэн зөвхөн хоёр улсын төдийгүй олон улсын тавцанд ч харилцан хамтын ажиллагааг бэхжүүлж, хөгжүүлэх ²⁷«Иж бүрэн түншлэлийн харилцааг бий болгох» тухай тунхагийг тодорхойлон гаргаж ирсэн.

(в) Монгол Улс, 1990 онд социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоонд нэн даруй шилжих тухай зарлан тунхаглаж, ардчилсан улс болохынхоо хувьд чөлөөт ардчилсан сонгуулиар улс төрийн тогтолцоогоо өөрчлөн тогтоосон бөгөөд адилхан ардчилсан орон болох Япон улсын хувьд нийтлэг улс төрийн нэгэн үзэл санаан дор хөгжлийн замыг замнаж буй Монгол улсын хүчин чармайлтыг өндрөөр үнэлж байна. Монголд зээл тусламж үзүүлэх замаар тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг

²⁷ 1997 оны 2 дугаар сард Японд хийсэн айлчлалын үеэр Ерөнхий сайд М.Энхсайхан (тухайн үеийн) болон Японы Ерөнхий сайд Р.Хашимото (тухайн үеийн) нар энэ тухай харилцан нотолж, 1998 оны 5 дугаар сард Ерөнхийлөгч Н.Багабанди Монгол Улсын төрийн тэргүүний хувьд анх удаа албан ёсоор Японд айлчлахдаа хоёр орны хоорондох «Иж бүрэн түншлэлийн харилцаа»-г хөгжүүлэх зорилтыг дахин бататгаж, «Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл»-г гаргасан юм. Улмаар, 2003 оны 12 дугаар сард Ерөнхийлөгч Н.Багабандийн албан ёсны айлчлалын үеэр гаргасан «Япон Улс, Монгол Улсын хамтарсан мэдэгдэл»-д Иж бүрэн түншлэлийн харилцаа амжилттай хөгжиж байгааг нотлон тэмдэглэж, хоёр орны харилцаа болон бүс нутаг, олон улсын хамтын нийгэмлэг дэх хамтын ажиллагааг улам хөгжүүлэхээр санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн юм.

дэмжих нь мөн нэгэн адил хүчин зүтгэл гаргаж буй бусад хөгжиж буй орны ардчилсан хөгжлийг дэмжиж байгаа хэрэг билээ.

(г) Монгол Улс чөлөөт, нээлтэй эдийн засгийг хөгжүүлэхээр тал бүрийн хүчин чармайлт гарган ажилласны хүчинд өнөөдөр өмч хувьчлалыг эрчимжүүлэх болон тогтолцоог бүрдүүлэх явцад тодорхой ахиц харагдаж байна. Цаашид үүн дээрээ тулгуурлан, дотоодын бие даасан үйл ажиллагаагаар хувийн хэвшлийг бэхжүүлэх зэрэг 33ЭЗ-ийн хөгжлийг улам бүр ахиулах шатанд дэвшин орно гэж хэлж болно. Энэхүү хүчин чармайлтыг дэмжих нь Хөгжлийн албан ёсны тусламжийн үндсэн зарчимд нийцэх бөгөөд тун ач холбогдолтой юм.

(д) Монголын байгаль орчин нь өвөрмөц онцлог байдлаараа манай бөмбөрцгийн болон хүн төрөлхтний хувьд үнэт зүйл болж байдаг билээ. Энэхүү өргөн уудам байгаль дунд үүсч хөгжсөн нүүдэлчин соёл ахуй, ардын дуу хөгжим зэрэг өвөрмөц өнгө төрх бүхий уламжлалт урлаг, түүний эх болсон байгаль нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байна. Нөгөө талаар, эрс хурдацтай өрнөж буй 33ЭЗ-ийн хөгжлийн явцад байгаль орчныг сүйтгэж, уламжлалт соёлын хөгжлийг орхигдуулж байгаа нь бодит үнэн юм. Өдгөө Монголын Засгийн Газар байгаль орчноо хайрлан хамгаалах, уламжлалт соёлоо хадгалан үлдээхийн тулд өөрсдөөс хамаарах хүчин чармайлтыг гаргахын зэрэгцээ дэлхий нийтэд хандаж энэ тал дээр хамтран ажиллахыг уриалж байгаа бөгөөд энэ үйл ажиллагааг дэмжин туслах нь дэлхийн дахины байгаль орчныг хамгаалах, уламжлалт соёлыг хадгалан хамгаалах үүднээс ихээхэн ач холбогдолтой юм.

(2) Монголд үзүүлэх тусламжийн чиг шугам

Дээр 2.(2)-т дурдсан Монголын засгийн газрын хөгжлийн стратегиуд бол эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах гэсэн үндсэн стратегийг хэрэгжүүлэх Монголын засгийн газрын өөрийн хүчин чармайлтын илрэл хэмээн үнэлж байна.

Япон улс Монгол улсын хөгжилд тулгарч буй бүх асуудлыг шийдвэрлэхдээ бус харин дээр 2.(2)-т өгүүлсэн Монгол улс өөрийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлон түүн дээрээ төвлөрч ажиллахад нь гол доноруудтай хамтран, түлхүү дэмжиж туслана. Монгол улс эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж, макро эдийн засгийн тогтворжилт ба төрийн байгуулагуудын үр өгөөжийг дээшлүүлэх замаар төсвийн алдагдлаа бууруулж, тусламж шингээх чадвараа нэмэгдүүлж, тэдгээрээс олсон хөрөнгөө ядуурлыг бууруулах болон байгаль орчноо хамгаалахад зарцуулах гэсэн харилцан уялдаатай бодлогыг хэрэгжүүлэхэд нь Япон улс ирэх 5-н жилд тусалж дэмжихийг зорьж байгаа юм. Энэхүү харилцан уялдаа холбоотой бодлогыг амжилттай хэрэгжүүлэх үүднээс Япон улсаас Монгол улсад үзүүлэх тусламж нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах Монголын талын өөрийн хүчин чармайлтыг дэмжих асуудлыг тэргүүн зорилгоо болгон, үүнд хүрэхийн тулд хөдөө орон нутгийн эдийн засгийн түвшинг дээшлүүлэхийн хамт мал аж ахуйн салбар дахь илүүдэл ажлын хүчийг өөр салбарт ажлын байр бий болгон шилжүүлэх асуудлыг дараагийн зорилгоо болгож байна. Эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд Япон улс Монгол улс дахь эрүүл макро эдийн засгийг бүрдүүлэх тогтолцоог сайжруулах болон боловсон хүчин бэлтгэхэд төрийн болон хувийн секторт хоёуланд нь туслахын хамт хот хөдөөгийн ялгааг арилгах зорилгоор хөдөөг хөгжүүлэхэд мөн туслана. Тэрчлэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг байгаль орчинтой хамт авч үзэн хөгжүүлэхийн тулд байгаль орчныг хамгаалахад туслана. Мөн гадаад валют олоход чиглэгдсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг эдийн засгийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс дэд бүтцийг хөгжүүлэх болон түүнтэй холбогдсон бодлого тодорхойлох зэрэгт тусалж дэмжинэ.

Ядуурлыг бууруулах асуудлыг үндсээр нь шийдвэрлэхэд эдийн засгийн өсөлт ихээхэн чухал нөлөөтэй гэсэн Япон улсын баримталж буй үндсэн ойлголт дээр тулгуурлан дээрхи чиглэлүүдийг тогтоосон бөгөөд ядуурлыг бууруулах асуудлыг үр өгөөжтэй хэрэгжүүлэх үүднээс сонгож авсан болно. Цаашилбал ядуучууд болон нийгмийн эмзэг бүлгийнхэнд шууд чиглэсэн тусламжийн хувьд жишээлбэл “Өвсний үндэс”, “Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”, “ТББ-ыг дэмжих буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаа” зэргээр дамжуулан ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримтална.

(3) Монголд үзүүлэх тусламжийн тэргүүлэх салбарууд

Дээрхи (2)-т дурдсан үндсэн чиг шугам дээр үндэслэн ойрын 5-н жилд Япон улсаас Монгол улсад үзүүлэх тусламж нь 1-рт 33ЭЗ-ийн тогтолцоог сайжруулах, боловсон хүчин бэлтгэхэд туслах, 2-рт Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж (Хөдөөгийн хөгжлийн бааз суурь болохуйц тодорхой загвар бүс нутагт туслах, Хөдөө аж ахуй, мал аж ахуйг сэргээхэд чиглэсэн тусламж), 3-рт Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж (байгаль орчныг хамгаалах болон түүний баялагыг зүй зохистой ашиглах, нийслэл УБ хот дахь байгаль орчны асуудлыг шийдвэрлэх), 4-рт Эдийн засгийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгоход туслах гэсэн 4-н салбарыг тусламжийн тэргүүлэх салбар болгож байна.

Эдгээр тэргүүлэх салбарууд нь Монголын засгийн газраас батлан гаргасан “Эдийн засгийн өсөлт Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг” (EGPRSP)-тэй яв цав нийцэж байгаа болно. Монголын засгийн газар EGPRSP-д тусгасан бодлого тус бүрийг хэрэгжүүлэх зорилгоор дунд хугацааны төсвийн хүрээг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ялангуяа нийгмийн хөгжлийн салбарын үйл ажиллагааны ахиц дэвшилийг хянахад “Мянганы хөгжлийн зорилт”-ын үзүүлэлтүүдийг (олон улсын “Мянганы хөгжлийн зорилт”-ын үзүүлэлтийг Монголын нөхцөлд тохируулан шинэчлэн тодорхойлсон үзүүлэлтүүд) ашиглахаар төлөвлөж байна. Иймээс Япон улсын тусламжийн үр өгөөжийг үнэлэх нэг хэлбэр нь Монголын засгийн газрын ашиглах эдгээр үзүүлэлтүүдийг ашиглах явдал юм.

(а) 33ЭЗ-ийн тогтолцоог сайжруулах, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж

Суурь боловсрол болон нарийн мэргэжил зэргийг сайн эзэмшсэн боловсон хүчин бэлтгэх нь эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэртэй гэдэг утгаараа маш чухал юм. Суурь боловсрол олгох салбарт сургуулийн байр хүрэлцээгүйгээс 3-н ээлжээр хичээллэх явдал, боловсролын агуулгын чанарыг дээшлүүлэх асуудал, 2005 оноос суурь боловсролыг 10-н жилийн тогтолцооноос 11-н жилийн тогтолцоонд шилжүүлсэнтэй холбогдон гарах боловсролын удирдлагын тогтолцоон дэхь асуудлууд, хөдөө орон нутгийн сургуулиудын сургалтын орчин муу байгаа явдал, багш нарыг давтан сургах асуудал зэрэг шийдвэрлэх ёстой асуудлууд шил шилээ даран хуримтлагдсаар байна. Мөн нарийн мэргэжлийн дадлага туршлага олгох сургалт нь ядуу хүмүүсийн ажлын байрыг нэмэгдүүлэх боломж олгодгоороо үнэхээр чухал болно.

Цаашилбал Монголын төрийн байгууллагуудыг бэхжүүлэхэд татвар хураалтын тогтолцоог бэхжүүлэх, хууль журмыг шинэчлэх зэрэг удирдлага хяналтын чадварыг сайжруулах, эдийн засаг, нийгмийн салбарын бодлого боловсруулах болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. Тэрчлэн хувийн хэвшлийн салбарын хувьд банк санхүүгийн тогтолцоог сайжруулах, жижиг дунд үйлдвэрлэл дэхь удирдлагын чадвар болон худалдаа арилжааны ноу хауг сайжруулах гэх мэт үйлдвэр аж ахуйн нэгжийн өсөлт хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох, гадаад худалдаа хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах нь амин чухал асуудал бөгөөд

үүнийг хэрэгжүүлэхийн тулд тогтолцоог сайжруулах болон боловсон хүчин бэлтгэх явдал нэн тэргүүнд шаардлагатай байна. Ялангуяа банк санхүүгийн тогтолцооны хувьд өндөр хүү, хөрөнгөний эргэлт дэхь саад тогтор зэрэг нь эдийн засгийн үйл ажилагааг боомилж байгаа бөгөөд хувийн хэвшил өсөн хөгжихөд саад болж буй энэ салбарт цаашид тогтолцоог сайжруулах болон боловсон хүчин бэлтгэх нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал болоод байна.

Дээр дурдсан тогтолцоог бэхжүүлэхэд болон боловсон хүчин бэлтгэхэд туслах тусламж нь ДНБ-ний 60 орчим хувийг үйлдвэрлэдэг нийслэл УБ хотын хувьд ч хөдөө орон нутгийн хувьд ч хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар ядуурлаас гарахад чухал арга хэмжээ болох юм. Япон улс энэ чиглэлийн тусламжаа хэрэгжүүлэхдээ 2002 онд нийслэл Улаанбаатар хотод байгуулагдсан хүний нөөцийг хөгжүүлэх “Монгол Японы Төв”-ийг мөн түшиглэх болно. Нөгөө талаар дээрхи арга хэмжээнүүдийг улам үр өгөөжтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд боловсрол эзэмшсэн боловсон хүчин нь гадаад руу гаралгүй Монгол улсынхаа эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулах тийм орчин нөхцөлийг Монгол улс бүрдүүлэх нь хамгаас чухал гэж бодогдож байна.

(б) Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж

(б)-1. Хөдөөгийн хөгжлийн бааз суурь болохуйц тодорхой загвар бүс нутагт үзүүлэх тусламж.

Монгол улсын нийслэл УБ хот болон хөдөө орон нутгийн ядуурлын асуудлыг үндсээр нь шийдвэрлэхэд хөдөөг хөгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж бодож байна. Хөдөөг хөгжүүлэхийн тулд юуны өмнө хөдөөгийн тулгуур хотуудад үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийг идэвхижүүлэх нь чухал юм. Энэ чиглэлийн хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламжийн хүрээнд усалгаатай тариаланг хөгжүүлэх зэрэг эдийн засгийн дэд бүтцийг сайжруулах, худалдаа наймаа зэрэг хувийн хэвшил болон үйлдвэрлэлд туслах, банкны бага хүүтэй бодлого хэрэгжүүлэх зэргээр дамжуулж хөдөө орон нутгийн эдийн засгийн суурь болсон газар тариалан, мал аж ахуйг сэргээх нь зүйтэй гэж бодож байна. Монголын уламжлалт аж ахуй болох бэлчээрийн мал аж ахуй болон илүү өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуй, мал аж ахуйг бүс нутаг тус бүрээр хөгжүүлэхийн тулд нэгдсэн бодлогын хүрээнд тодорхой нэг асуудлыг шийдэж явах нь чухал юм. Хөдөө орон нутаг дахь аялал жуулчлалыг хөгжүүлэх баялаг нөөц болон газрын хэвлий дэхь баялагаа зүй зохистойгоор ашиглан хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатай.

Мөн хөдөө орон нутгийг хөгжүүлэхийн тулд хөдөө орон нутаг дахь эмнэлэг, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулах нь чухал асуудал бөгөөд үүний тулд эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах эмнэлгийн боловсон хүчний түвшинг дээшлүүлэх шаардлага гарч байна. Нөгөө талаас Монгол шиг өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг суурьшсан улсад олон төрлийн тусламжийг бүгдийг хөдөө орон нутагт хэрэгжүүлэх нь зардал нь үр ашгаасаа давах утгаараа хүндрэлтэй бөгөөд харин Монголын засгийн газрын тогтоосон хөдөөгийн хөгжлийн тулгуур бүс нутаг дотроос тодорхой нэгийг сонгон загвар болгон тухайн бүс нутгийн ерөнхий хөгжилд туслах нь тусламжийн үр өгөөжийг илүү нэмэгдүүлнэ хэмээн бодож байна.

(б)-2. Бэлчээр болон хөдөө аж ахуй, мал аж ахуйг сэргээхэд чиглэсэн тусламж

Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт учирдаг бэлчээрийн даац хэтэрснээс үүдэлтэй цөлжилт, ган, зуд зэрэг нь Монгол улс дахь ядууралд ихээхэн нөлөөлдөг гэж үзэж байна. Иймээс дээр дурдсан загвар бүс нутагт байгаль орчныг хамгаалахад анхаарахын сацуу тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах үүднээс цөлжилт, ган зудын нөлөөгөөр унаж доройтсон мал аж ахуй, газар тариалангийн дотроос зөвхөн эдийн засгийн үр ашгийг харалгүй ядуурлыг бууруулахад үр өгөөжтэй газрыг олж

тогтоон тэнд илүүтэйгээр тусалж дэмжих шаардлагатай хэмээн бодож байна.

Монгол улсын уламжлалт аж ахуй болох бэлчээрийн мал аж ахуй, хөдөө аж ахуйг сэргээхийн тулд нэгдсэн бодлогын хүрээнд асуудалд хандах нь чухал бөгөөд Япон улсын хувьд ч өнөөг хүртэл үзүүлж ирсэн тусламжийн үр дүн дээрээ тулгуурлан цөлжилт, ган, зудтай тэмцэх, ноос, ноолуур, сүүний үйлдвэрлэлийг сайжруулах болон үр тариа ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлүүдийн дотроос сонгон тусламж үзүүлэх нь чухал гэж бодогдож байна. Мөн эдгээрийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд хувь нэмэр болохуйц тогтолцоог бүрдүүлэх, холбогдох технологийг нэвтрүүлэх зэрэгт ч мөн туслах нь чухал юм.

(в) Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж

(в)-1. Байгаль орчныг хамгаалах болон түүний баялгийг зүй зохистой ашиглах

Монголын байгаль нь олон төрлийн экологийн тогтолцоотой бөгөөд олон улсын хэмжээнд ч ховорт орох зэрлэг ан амьтантай олон төрлийн биологийн төрөл зүйл бүхий байгаль юм. Монголчууд уг нь нүүдлийн амьдралд зохицсон байгалийнхаа баялгийг ашиглахын сацуу байгаль орчноо хамгаалж ирсэн уламжлал байсан хэдий ч 1990 оноос хойших эмх замбараагүй үйл ажиллагааны улмаас зэрлэг ан амьтан, ургамал, бэлчээр, ой мод зэрэг байгалийн баялгийн ашиглалт хэт ихсэх хандлагатай болоод байна. Монгол улс 1992 онд Биологийн төрөл зүйлийг хамгаалах гэрээ, 1994 онд Цөлжилттэй тэмцэх конвенци зэрэг байгаль орчныг хамгаалах олон улсын гэрээ ковенцид идэвхитэй нэгдэн орсон хэдий ч дотооддоо тэдгээрийг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажил удаашралтай явагдаж байна. Үүнд байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн акт бүрэн бус, гүйцэтгэх болон хяналтийн тогтолцоо сул, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах арга техник дутагдалтай байгаа, ховор зэрлэг ан амьтан, ургамлыг хамгаалах арга техник дутагдалтай байгаа, ан амьтадын нарийн тоо толгой зэрэг шинжлэх ухааны чанартай мэдээллийн дутагдал зэрэг шалтгаанууд байгаа бөгөөд эдгээрийг сайжруулах чиглэлд тусламж үзүүлэх нь үр дүнтэй гэж бодож байна.

Монгол улсад ган, зуд, ой хээрийн түймэр зэргээс үүдэн бэлчээр муудах, цөлжилт, улмаар эдгээрийг даган шар шороон шуургын үзэгдэл улам бүр нэмэгдэх болсон нь санаа ихээхэн зовоож байна. Тэрчлэн дэлхийн цаг уурын дулаарлаас үүдэлтэй гэж үздэг мөсөн голын хайлалт, нуур цөөрөм, гол мөрний ус ширгэх зэрэг үзэгдэл ч мөн гарах боллоо. Гэвч эдгээрийн уг шалтгааныг шинжлэх ухааны үндэстэйгээр тайлбарлах түвшинд одоогоор хүрээгүй байгаа бөгөөд цаг уур байгаль орчны нэгдсэн мониторинг болон байгаль орчны мэдээлэл дээр үндэслэн бодит байдлыг таньж мэдэн урьдчилан сэрэмжлүүлэх, гамшгаас хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих нь чухал юм.

Монгол улсын хөгжилд байгаль орчны холбогдолтой асуудлуудыг сайтар харгалзан үзэх нь маш чухал юм.

Мөн Монголын байгаль нь өвөрмөц соёлыг үүсгэдэг гэдэг утгаар нь ч түүнийг хамгаалах нь чухал юм. Үүнээс гадна байгалийн баялаг нь засгийн газраас хөхүүлэн дэмжиж буй аялал жуулчлалын хөгжүүлэх бодлогын эх суурь болж байгаагаараа ач холбогдолтойгоос гадна ургамал ан амьтан, байгалийн баялгийг ашиглах нь орон нутгийн ард иргэдийн орлогын давхар эх үүсвэр болно гэдгийг анхаарахгүй орхигдуулж болохгүй. Иймээс ядуурлыг бууруулах болон тухайн бүс нутгийн онцлогтой уламжлалт соёлыг хамгаалахад хувь нэмэр болохуйц хэлбэрээр байгаль орчныг хамгаалах болон түүний баялгийг зүй зохистой ашиглахад тусалж дэмжих шаардлага байна. Мөн үүнийг хэрэгжүүлэхэд тухайн бүс нутгийн ард иргэдийн оролцоо чухал гэж үзэж байна.

(в)-2. Нийслэл УБ хот дахь байгаль орчны асуудлыг шийдвэрлэх

Сүүлийн жилүүдэд ган зуд зэргээс шалтгаалан хөдөө орон нутагт амьдрах боломжгүй болсон ард иргэд нийслэл Улаанбаатар хот руу ихээр шилжин ирэх болсон зэргээс үүдэн УБ хотын хүн ам үнэн хэрэгтээ 1 сая 100 мянгад хүрсэн гэгдэх боллоо. Ингэж хүн ам хотод төвлөрөх болсноос шалтгаалан гэр хорооллынхны нүүрсний хэрэглээ зэргээс болж агаар бохирдох, хотын иргэдийн хог, үйлдвэрлэлийн хаягдал зэргээс үүдэн хог боловсруулах асуудал, усны бохирдол зэргээр хот орчмын байгаль орчин муудаж доройтсоор байна.

Монгол улсад байгаль орчныг хамгаалахтай холбогдсон стандарт, хог хаягдлыг боловсруулах хууль зэрэг тогтолцоо байгаа хэдий ч хянаж зохицуулах чадвар сул учир цаашид түлэх нүүрсийг сайжруулах, хотын байгаль орчны удирдлагын боловсон хүчин бэлтгэх зэргийг хамруулсан тусламж, хог хаягдлыг боловсруулах тогтолцоонд чиглэсэн тусламж, усны бохирдолттой тэмцэх зэрэгт чиглэсэн тусламж хамтын ажиллагаа байж болох юм.

(г) Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгоход үзүүлэх тусламж

Дэд бүтцийн салбар нь Монголын эдийн засгийн хөгжлийн үндэс суурь юм. Одоо байгаа байгууламжууд нь хуучин ЗХУ-ын тусламжаар байгуулагдсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь хуучирч муудсан тул тэдгээрийг шинэчлэн сайжруулах нь улам бүр чухал болж байна. Энэхүү тусламжийн хөтөлбөрт ойрын 5-н жилд дэд бүтцийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэхээр тусгаж байгаа нийслэл болон хөдөө орон нутгийн тулгуур хотуудад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ард түмний амьдралтай шууд холбоотой мэдээлэл холбоо зэрэг үндсэн дэд бүтэц, мөн дээрхээс гадна аялал жуулчлал хөгжүүлэх, газрын хэвлийн баялгийг ашиглах зэрэг гадаад валют олох үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тус нэмэртэй тээврийн салбарыг сайжруулахтай холбогдсон хамтын ажиллагааг ч мөн санаж явах нь чухал юм.

Цаашид Сибирийн дорнод хэсэг, Хятадын зүүн хойт хэсгийн дэд бүтцийн хөгжлийн хандлагыг харгалзахын зэрэгцээ Хятад, ОХУ-тай хиллэх бүс нутагт хэдийнэ эхэлсэн ашигт малтмал олборлох, худалдаа наймаа, хамтарсан зах зээл зэрэг Зүүн Хойт Азитай холбогдох эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих чиглэлийн дэд бүтцийг дунд хугацаанд хэрэгжүүлэхийг ч мөн санаж явах ёстой хэмээн бодож байна.

(4) Монголд тусламж үзүүлэхэд анхаарах зүйлс

(а) Бодлогын зөвлөлдөх уулзалт

Тусламжийг үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс төслийг боловсруулах, сонгох, хэрэгжүүлэх асуудлуудаар Монголын засгийн газартай нягт хамтран ажиллаж, бодлогын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулна. Энэхүү бодлогын зөвлөлдөх уулзалт нь, Монголын засгийн газрын идэвхи санаачилгатай байдлыг бий болгоход туслана гэж үзэж байна. Мөн, тусламж үзүүлэхэд тохиромжтой тусламжийн хэлбэр, цаашилбал хэлбэр хоорондын үргэлжлэх чанар болон уялдаа холбооны тухайд ч уг бодлогын зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэх болно.

(б) Бусад донорууд, Японы болон Монголын ТББ-тай уялдаа холбоотой ажиллах

Монгол улс нь олон тооны хандивлагч орнууд болон олон улсын байгууллагуудаас тусламж дэмжлэг авч байгаа хэдий ч, манай орны хувьд анхнаасаа хамгийн том хандивлагчийн байр сууриа хадгалж ирсэн бөгөөд цаашид ч голлох байр сууринаас иж бүрнээр харилцаа, хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно гэдэгт найдвар тавигдаж байгаа юм. Үүний зэрэгцээ үр өгөөж бүхий нягт харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд, Монгол улс нь дотоодын идэвхи

санаачилгатай байдлаа улам бүр идэвхжүүлэн дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. 2004 оны 4 сард Монголын засгийн газраас боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн салбарын тусламжийн үр ашгийг дээшлүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг зохион байгуулж, манай улс, Азийн Хөгжлийн Банктай хамтран боловсролын асуудал хариуцсан ажлын хэсгийн хуралдааны дэд даргын үүргийг гүйцэтгэх болсон билээ. Цаашид, дээр өгүүлсэн Монголын талын идэвх санаачилгыг хүндэтгэн үзэхийн зэрэгцээ нийт хандивлагчид Монголд үзүүлэх тусламжийнхаа үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд бодлого чиглэлээ харилцан зөвлөлдөх зэргээр хүчин чармайлт тавих нь чухал юм. Түүнчлэн, бодлогын зөвлөлдөх уулзалт болон хандивлагчид хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд, Монгол дахь Японы засгийн газрын төлөөлөлийн тогтолцоогоо бэхжүүлэх шаардлага урган гарч байна.

Мөн, Монголд үзүүлэх тусламжийг үр ашигтай хэрэгжүүлэх зорилгоор Төрийн бус байгууллагуудыг хамарсан ард иргэд хоорондын харилцааны үйл хөдлөлийг сайтар анхааралдаа авах явдал чухал юм. Япон Монгол хоёр орны харилцаа нь, Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш эрчимтэй хөгжиж, ялангуяа ард иргэднийн түвшинд харилцаа гүнзгийрсээр ирсэн. Эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт ч Японы Төрийн бус байгууллагууд Монголын хөгжлийн шаардлагад нийцсэн нарийн тусламж дэмжлэгийг үзүүлсээр ирсэн ба Японы засгийн газрын зүгээс шаардлагатай үед тэдгээрийн үйл хөдлөлийг дэмжин туслаж, ард иргэдийн оролцоотой эдийн засгийн хамтын ажиллагааг буй болгох явдал нь хоёр орны харилцааг бэхжүүлэх үүднээс авч үзсэн ч нэн чухал болоод байна.

(в) Гадаад өрийн асуудал болон тусламж шингээх чадвар

Монгол улсын гадаад өрийн албан ёсны хэмжээ барагцаалбал ДНБ-нийх нь 94.0 хувьтай тэнцэхүйц хэмжээнд өсч, ОУВС зэрэг байгууллагууд ч энэ талаар маш их санаа зовж байгаа тухай илэрхийлж ирсэн. Мөн өр барагдуулалтын хэмжээ 6.7 хувьтай байгаа нь хөгжиж буй орны хувьд харьцангуй доогуур төвшинд багтаж байна. Сүүлийн жилүүдэд эдийн засаг нь сэргэж байгаа тул дээр дурдсанчлан голчлон олон улсын байгууллагуудаас цаашид хөнгөлөлттэй зээлийг хязгаарлагдмал хэмжээнд авах боломжтой гэсэн саналууд давамгайлж ирж байна. Мөн, сүүлийн үед үүсээд байсан хуучин ЗХУ-д төлөх их өрийн тухайд гэвэл, 2003 оны 12 сарын эцсээр уг асуудал эцэслэн шийдэгдсэн бөгөөд энэ нь дотоодын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байгаа хэдий ч, гадаад өрийн асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлт нь үнэлүүштэй юм. Ялангуяа, цаашид Монгол улс дээр дурьдсанчлан эдийн засгийн бааз сууриа сайжруулахад гол анхаарлаа хандуулах шаардлагатай бөгөөд үүний хамтаар ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгөний хэрэгцээ шаардлага урган гарах төлөв ажиглагдаж байгаагаас тусламж авах болон хэрэгжүүлэх дотоод тогтолцоогоо бэхжүүлэх, албан зардлын удирдлагын чадавхийг дээшлүүлэх асуудал нь улам бүр чухлаар тавигдаж байна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулалтыг хүлээн авах тогтолцоог бүрдүүлэх, өөрөөр хэлбэл мөнгө санхүүгийн тогтолцоог өргөжүүлэх нь ч чухал асуудал буй заа. Монгол улсын Япон улсаас авсан йений үндсэн зээлийн болон хүүгийн эргэн төлөлт нь ойрын жилүүдэд оргил хэмжээндээ хүрэх учраас Япон улс Монгол улсын өр барагдуулалтын байдлыг анхааралтай ажиглаж байна.

Мөн, тусламжийн хөрөнгийг шингээх чадварын тухайд дурдвал, Монголын улсын Засгийн газрын яамд хоорондын ажлын уялдаа холбоог хангалттай гэж хараахан хэлж чадахгүй байна. Засгийн газар хоорондын зөвлөлдөх уулзалтуудын үеэр дотооддоо идэвхи санаачилгатай ажиллахыг сануулахын зэрэгцээ яамд хоорондын уялдаа холбоо муутай тогтолцоогоо засаж залруулах талаар дахин дахин сануулах шаардлага ч урган гарч байна. Монголын Засгийн газар энэ асуудлыг зөвөөр ойлгон хүлээн

авч байгаа бөгөөд 2003 оны 6 сард Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийг батлан, яам тамгын газруудынхаа үүрэг хариуцлагыг тодорхой тогтоож өгсөн билээ. Цаашид, уг хуулийн дагуу тусламж үйл ажиллагаа хэвийн явагдана гэдэгт найдаж байна. Үүний хамт, засаглалыг бэхжүүлэх тухай хүсэлт тавих хэрэгтэй юм.

(г) Байгаль, нийгэмд үзүүлэх нөлөөллийг сайтар анхаарах нь

Эдийн засгийн бааз суурийг сайжруулахтай холбогдон, байгаль орчин болон бүс нутгийн нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байдгаас тодорхой төсөл төлөвлөгөөнүүдийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон нийгмийн асуудлууд, ялангуяа хүйсийн тэгш эрхийн байдалд үзүүлэх нөлөөллийг сайтар анхааралдаа авах шаардлагатай.

(д) Тусламжийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн үнэлгээ

Энэхүү тусламжийн хөтөлбөрийн хүчинтэй хугацаа нь 5 жил орчим бөгөөд уг хөтөлбөрт үндэслэн тусламжийн үйл ажиллагааг үр ашигтай, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд тусламжийн хөтөлбөрийн хяналтын тогтолцоог буй болгох явдал чухал юм. Монгол улс дахь “ХАЁТ-ын ажлын хэсэг” буюу Японы ЭСЯ болон JICA-ийн төлөөлөгчийн газар жил бүр тэргүүлэх салбар бүрийн төслийн боловсруулалт, хэрэгжилтийн байдал болон дээр дурдсан тусламжийн төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлүүдэд тусгагдсан байдлуудад гол анхаарлаа хандуулан, энэхүү тусламжийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт тавина. Энэхүү хяналтын үр дүн нь, уг хөтөлбөр эцэслэн шийдэгдсэнээс хойших ойролцоогоор 4 жилийн хугацаанд гуравдагч этгээдийн үнэлгээг явуулахад үндсэн материал болно.

* * *

Э/з-ийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах, мянганы хөгжлийн зорилтуудыг хангах

